

**ДОРНОД СЭРГЭН МАНДАЛТ**

**ДОРНОД АЙМГИЙН 2016-2025 ОНЫ  
ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ**

*Дорнод аймаг*

*Монгол Улсыг Зүүн Хойд Азийн эдийн засгийн  
интеграцид холбох гүүр, зангилаа бүс нутаг*

*Чойбалсан хот*

*2016 оны 5-р сарын 12*

## **Агуулга**

УДИРТГАЛ.....	3
НЭГ. ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР. ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮНДСЭН ЗАРЧМУУД.....	5
ГУРАВ. ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ОНЦЛОГ.....	7
ДӨРӨВ. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ХӨГЖЛИЙН ЭХ СУРВАЛЖ, БОЛОМЖУУД.....	11
ТАВ. ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА.....	13
ЗУРГАА. ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД.....	14
ДОЛОО. ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	52
НАЙМ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	55
ЕС. ХАВСРАЛТ.....	57

## УДИРТГАЛ

Монгол Улс сүүлийн 20 жилд хөгжлийн тодорхой ахиц амжилт гаргаж, дэлхий нийт болон бүс нутгийн эдийн засаг, хамтын ажиллагаанд идэвхтэй нэгдэж, хөгжиж буй орны нэгэнд зүй ёсоор орсон нь чухал дэвшил юм. 1996 онд “Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал”, 2008 онд “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” зэрэг хөгжлийн томоохон баримт бичгүүдийг баталж хэрэгжүүлсний үр дүн нь эдийн засаг, нийгмийн хөгжилд ихээхэн түлхэц болсон. Эдгээр хөгжлийн баримт бичгүүд Дорнод аймгийн хэмжээнд тодорхой зохион байгуулалттай хэрэгжиж, үр өгөөжөө өгснийг онцлон тэмдэглэж байна.

УИХ-аар 2015 онд баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг 2016-2030 онд хэрэгжүүлэхээр 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр УИХ-ын 19 дүгээр тогтоолоор баталсан юм.

Энэхүү Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь дэлхий нийтийн хөгжлийн хандлагатай уялдан улс орныхоо эдийн засаг, нийгмийн онцлогийг тусгаж, тулгарч байгаа гол сорилтуудыг даван туулах, тогтвортой хөгжлийн зорилго, хүний хөгжлийг хангахад чиглэсэн үндэсний урт хугацааны шинэ бодлого болсон юм.

Ийнхүү үндэсний түвшинд хөгжлийн бодлого боловсруулах үндэслэл тавигдсанаар Дорнод аймгийн Засаг даргын 2015 оны А/343 тоот захирамжаар Дорнод аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ажлын дэд хэсэг байгуулан уг баримт бичгийг боловсруулах уралдаант шалгаруулалтыг зарлаж, “Бүсчилсэн хөгжлийн бодлогын судалгааны төв” ТББ-ын эрдэмтэн, судлаачдын баг шалгарч, “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт” бодлогын баримт бичгийг аймгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор шинжлэх ухааны аргазүй, судалгаанд тулгуурлан боловсруулж, аймгийн ИТХ-ын 2016 оны 5-р сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн баталсан.

Дорнод аймаг хөгжлийн дунд хугацааны бодлогоо шинэчлэн тодорхойлж байгаа нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн бололцоогоо илүү оновчтой ашиглах, гадаад, дотоод орчны нөлөөлөлд зохистой нийцүүлэх, цаашдын эрчимтэй хөгжлийн бололцоог нээлттэй байлгах нөхцөл бүрдүүлж байна. Дунд хугацааны хөгжлийн хэтийн зорилт нь Дорнод аймгийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээг тодорхойлж, хөгжлийн нэгдмэл зорилгод чиглүүлнэ.

Энэхүү хөгжлийн баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвтэй уялдан үе шаттай хэрэгжиж, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, жил бүрийн үндсэн чиглэл, дэд хөтөлбөр зэрэг гол баримт бичгүүдэд тусгалаа олж биелэх болно.

# НЭГ. ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, урт хугацаанд нэгдсэн зорилго, чиглэлтэйгээр хөгжих зайлшгүй шаардлагад үндэслэн Монгол Улсын Их Хурлаас “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” (2015 онд), “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (2016 онд)-ыг баталсан.

Улс төрийн аль ч хүчин төр барихаас үл хамааран Монгол Улс ирэх 15 жилд баримтлах хөгжлийн бодлогоо тодорхойлон, түүнийгээ дагаж мөрдөх эрх зүйн орчин бий болсон нь Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа хөгжлийн баримжаагаа урт хугацаанд, тогтвортойгоор төсөөлөх боломжийг олгож байна.

Энэ цаг үетэй давхцан “Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр”(2006-2015), “Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлого”(2009-2016) баримт бичгүүдийн хэрэгжилтийн хугацаа дуусгавар болж байгаа тул Дорнод аймаг нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ажил, хүрсэн амжилт, алдаа оноогоо дэнслэн, ирэх жилүүдэд баримтлах хөгжлийн чиг баримжаагаа эрх зүйн шинэ орчинд тулгуурлан дахин тодорхойлох хэрэгцээ гарсан.

Түүнчлэн Зүүн бүс, Дорнод аймгийн хэмжээнд тулгамдаж буй хүн амын шилжин явах хөдөлгөөн, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгэм, эдийн засгийн асуудлууд, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, даяаршил, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөрөнгө оруулалтын чөлөөтэй урсгал зэрэг гадаад орчны хүчин зүйлсийг харгалзан хөгжлийн боломжуудаа тодорхойлж, иргэдийнхээ амьжиргаа, амьдрах орчныг сайжруулах зайлшгүй шаардлага үүссэн.

Дорнод аймаг нь Зүүн бүсийн эдийн засгийн хөгжлийн тулгуур төв болохын хувьд “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт” бодлогын баримт бичиг нь бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Энэхүү баримт бичиг нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг иш үндэс болгон байгалийн баялаг, газарзүйн байршлын давуу талуудад тулгуурлан эдийн засгийн салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, олон тулгуурт бүтцийг бий болгох замаар иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлж, бүс нутгийн хөгжлийн төв, Монгол Улсын хөгжлийн зүүн багана болоход чиглэгдсэн болно.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал<sup>1</sup>, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлого<sup>2</sup>, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр болон төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагуудаас улсын, бүсийн, орон нутгийн хөгжилтэй холбогдон гаргасан тогтоол шийдвэр, төсөл, бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа нь “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт”-д тусгалаа олсон бөгөөд уг баримт бичгийг боловсруулах үндэслэл болно.

---

<sup>1</sup>УИХ-ын 2010. 7. 15-ны өдрийн 48 дугаар тогтоол

<sup>2</sup>УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол

# ХОЁР. ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮНДСЭН ЗАРЧМУУД

Иргэдэд сайн сайхан аж төрөх боломжийг тэгш олгож, эдийн засаг, нийгмээ хөгжүүлж, хүрээлэн байгаа орчны тэнцвэртэй байдлыг хадгалсан тогтвортой, хүртээмжтэй хөгжил нь Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтын гол үзэл баримтлал бөгөөд хэтийн зорилтыг тодорхойлохдоо ард иргэдийн нийтлэг эрх ашиг, сайн сайхан байдлыг хангахыг гол зарчим болгосон. Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтын үзэл баримтлалыг тодорхойлох, хөгжлийн зорилт, бодлогын чиглэл, тэдгээрийн үндэслэлийг боловсруулахдаа шинжлэх ухааны судалгааны арга зүйд тулгуурлах дэлхийн нийтлэг зарчмыг баримталсан болно.

Хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулахад дараах хандлагуудыг баримтлав. Үүнд:

**Нэгдүгээрт**, энэхүү хэтийн зорилт нь аймгийн хөгжлийн тулгуур баримт бичиг болох учир өмнөх хөгжлийн бодлогын хэрэгжүүлсэн туршлага сургамжийг харгалзахын зэрэгцээ хөгжлийн бодлого боловсруулах олон улсын хандлагыг харьцуулан үзэж, аргагүйн хувьд ахисан байхад анхаарав.

**Хоёрдугаарт**, бодлогын баримт бичгийг боловсруулах үйл явц нь бүхэлдээ судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлах буюу өмнөх туршлага, өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хандлагыг судалж тодорхойлон дотоод болон гадаад орчин нөхцөл, дотоод боломж, нөөц, эдийн засгийн чадамжид нийцүүлэн боловсруулахыг эрхэмлэв.

**Гуравдугаар**, орон нутгийн хөгжил дэвшил, ирээдүйн сайн сайхны төлөөх иргэд, төрийн байгууллагууд, шийдвэр гаргагчид, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудын санаа бодол, хүсэл эрмэлзлийг тусгахыг чухалчлав.

## **Хэтийн зорилтын үзэл баримтлал**

Уг хэтийн зорилт нь 2025 он хүртэлх хугацаанд Дорнод аймгийн хөгжлийн зорилт, бодлогын чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагааг тодорхойлон, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн урьдач нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн.

Хэтийн зорилт нь Дорнод аймгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлж, хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, олон тулгуурт эдийн засагт суурилсан тогтвортой хөгжлийг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалж, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах ерөнхий зорилгыг агуулахын зэрэгцээ хөдөө аж ахуй, аялал жуулчлал, өндөр технологийн аж үйлдвэрт түшиглэсэн эдийн засаг, хүн төвт нийгмийн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан. Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилт нь орон нутгийн засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжил, хүрээлэн буй орчин, хот байгуулалтын асуудлын уялдаа, шүтэлцээг харгалзан авч үзсэн болно.

### *Хүн төвтэй нийгмийн хөгжлийн үзэл баримтлал*

Иргэдийн ажиллаж амьдрах, сурч боловсроход таатай эрүүл орчинг бүрдүүлэх, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх, бүтээлч чадамж, санаачлагыг дэмжих, тогтвортой орлого, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг сайжруулах, ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн.

### *Олон тулгуурт, тогтвортой эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал*

Эдийн засгийг төрөлжүүлэн шинэ, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортоор үндэсний болон хил залгаа орнуудын зах зээлд байр сууриа эзлэх, импортоос хараат

байдлаа бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, салбаруудын уялдааг сайжруулан дотоод үр ашгийг дээшлүүлэх замаар эдийн засгийн бие даасан байдал, тогтвортой байдлын суурийг бэхжүүлж, аймгийн ДНБ-ийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

#### *Эрүүл, аюулгүй амьдрах орчин бүхий экологи, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал*

Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны хяналт шинжилгээ, мэдээлэл, ил тод байдлын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэнэ. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тогтвортой байдалтай уялдуулах, төр, иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, санаачлагыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

#### *Хотын хөгжлийн үзэл баримтлал*

Зүүн бүсийн тулгуур төвийн хувьд Чойбалсан хотыг хүний амьдрах тав тухтай орчныг бүрдүүлсэн, хүрээлэн буй орчиндоо сөрөг нөлөө багатай, бүсийн нийгэм, соёл, эдийн засаг, санхүүгийн төв байх ухаалаг, жишиг хот, мэдлэг-оюуны төв болгон хөгжүүлэх үзэл баримтлалд тулгуурлана.

#### **Хэтийн зорилтын үндсэн зорилго, баримтлах зарчмууд**

Хэтийн зорилтын үндсэн зорилго нь үндэсний болон салбарын хөгжлийн баримт бичигт үндэслэж, аймгийн хөгжлийн чадамж, нөөц, боломж, дотоод, гадаад орчны нөхцөл, иргэд, бизнес эрхлэгчид, төр, олон нийтийн байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, санал санаачилгад тулгуурлах ба үүнд хүрэхэд чиглэсэн дараах зорилтуудтай байна. Үүнд:

- ❖ Хүний хөгжлийг хангаж, бүтээх чадварыг нэмэгдүүлэн, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх,
- ❖ Орон нутгийн нөөц боломж, бүс нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах,
- ❖ Мэдлэг оюун, өв соёлын баялаг хуримтлал бүрдүүлэн, технологи, инновацийн хүчтэй чадамжийг бий болгож, шинэ техник, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх,
- ❖ Хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө, байгалийн баялгийн нөөцийг үр өгөөжтэйгээр ашиглах, хүрээлэн байгаа амьдрах орчноо эрүүл байдлаар нь хадгалах,
- ❖ Бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд төр, захиргааны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хил залгаа орнуудтай харилцан үр ашигтайгаар хамтран ажиллах юм.

Хэтийн зорилтыг боловсруулахад дараах зарчмуудыг баримтлав. Үүнд:

- ❖ Улс орны болон аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэлийг үндэс болгох,
- ❖ Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх,
- ❖ Эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны бодлогын харилцан уялдааг хангах,
- ❖ Эдийн засгийн үр ашиг, үр өгөөжид үндэслэх,
- ❖ Үр ашигтай дэд бүтцийг байгуулах,
- ❖ Үйлдвэрлэлийн технологийн хөгжил, боловсруулалтын түвшинг харгалзах,
- ❖ Оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцан ашигтай түншлэлд тулгуурлах,
- ❖ Удирдлагын манлайлал, оролцогч талуудын хяналт оролцоог хангах зэрэг болно.

# ГУРАВ. ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ОНЦЛОГ

*Дорнод аймгийн хөгжлийн ойрын арван жилийн хэтийн зорилтыг томъёолоход өнөөгийн нөхцөл байдлын дараах онцлогуудыг харгалзах шаардлагатай.*

Дорнод аймаг нь эдийн засгийн хувьд уул уурхай, цахилгаан эрчим хүч зэрэг аж үйлдвэр болон газар тариалан, мал аж ахуй хослон хөгжсөн бөгөөд байгалийн үзэсгэлэнт унаган төрхөө хадгалсан, халх, буриад, үзэмчин, барга угсаатны бүлгүүд болон эх орны тусгаар тогтнолын төлөөх дайны дурсгалт газрууд зэрэг түүх, соёл, уламжлалын өлгий нутаг юм. Газарзүйн байршлын хувьд хоёр улстай хиллэж, зөвхөн Зүүн бүсийн төдийгүй, хил дамнасан бүс нутгийн эдийн засаг, худалдааны зангилаа төв болж, аялал жуулчлал, газар тариалан, хүнс, ХАА-н үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих таатай нөхцөлтэй бөгөөд Монгол Улсын далайд гарах олон гарцын уулзвар болох хилийн 6 боомттой, агаарын тээвэр, төмөр зам, эрчим хүч, уул уурхай зэрэг бусад аймаг, хотуудтай харьцуулахад хөгжлийн олон давуу талтай юм.

Дорнод аймгийн 14 сум, 66 багт 2015 оны байдлаар 74.9 мянган хүн (22.4 мянган өрх) буюу улсын нийт хүн амын 2,5 хувь оршин суудаг. Аймгийн хүний хөгжлийн индекс 2014 онд 0.723 буюу улсад 21 аймгаас 5-рт, хүн амын дундаж наслалт 68,4 жилээр 19-рт орж байна. Хүн амын шилжин явах хөдөлгөөнийг бууруулж, тогтвортой ажлын байр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах нь хөгжлийн томоохон сорилт болж байна. Дорнод аймаг 2014 оны байдлаар жилдээ 619.5 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 21 аймгаас Орхон аймгийн дараа улсад 2-рт, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 8.3 сая төгрөгт хүрч<sup>3</sup>, Орхон, Өмнөговь аймгийн дараа улсад 3-рт орж, улсад тэргүүлэх 3 аймгийн нэг болж байна.

Дорнод аймгийн эдийн засгийн салбарын бүтэц бусад аймгуудаас ялгаатай бөгөөд гол салбар нь аж үйлдвэр юм. 2014 оны байдлаар аймгийн ДНБ-д аж үйлдвэрийн салбар 67.5 хувь, хөдөө аж ахуй 14.5 хувь, үйлчилгээний салбар 18.0 хувийг эзэлж байгаа нь уул уурхай, цахилгаан эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь бусад аймгуудаас илүү хөгжсөнийг харуулж байна. Аймгийн хэмжээнд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй бага бөгөөд сүүлийн жилүүдэд аймгийн эдийн засагт нэмүү өртөг бага шингэсэн уул уурхай, цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн хэмжээ хурдацтай нэмэгдэж байна.

Дорнод аймаг нь дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах харьцангуй давуу нөхцөлтэй<sup>4</sup> бөгөөд уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжүүлэх газрын баялаг нөөцдөө тулгуурлан технологи шингээсэн үйлдвэрлэл бүхий үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл бүхий газар тариалан, мах, сүүний чиглэлийн экспортын баримжаатай эрчимжсэн фермерийн аж ахуй хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн бүс нутаг, дэлхийн зах зээлд гаргах боломжтой юм.

## **Нийгмийн салбар:**

Дорнод аймгийн хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүний хөгжлийн индексийг өсгөх нь нийгмийн салбарын гол зорилт болох юм. Өнөөгийн байдлаар нийгмийн салбарын хамгийн тулгамдсан асуудал

<sup>3</sup>Үндэсний Статистикийн хороо, 2015, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл-2014

<sup>4</sup>БНХАУ-ын Хөлөнбуйр, Хянган аймаг, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаартай хиллэх ба цаашилбал Зүүн хойд Азийн 1.5 тэрбум хүн ам бүхий зах зээлтэй ойр байршиж байна.

нь ажилгүйдэл, ядуурал, хүн амын шилжин явах хөдөлгөөн болж байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд буюу 2000-2014 онд нийт 27.3 мянган хүн Дорнод аймгаас шилжин явсан бол 8.8 мянган хүн тус аймагт шилжин ирсэн. Ажилгүйдлийн түвшин 2015 оны 4-р улирлын байдлаар 7.8 хувь<sup>5</sup> байгаа ч хүн амын дийлэнх хэсэг нь хот, суурин газарт суурьшдаг нь хотод шинээр үйлдвэр, аж ахуйн газруудыг байгуулах хөдөлмөрийн нөөц сайн байгааг харуулж байна. Хүн амын төрөлтийн түвшнээр бусад аймгуудаас харьцангуй өндөр бөгөөд нас баралтын түвшнээр 2015 оны 4-р улирлын байдлаар улсад Хөвсгөл аймгийн дараа 2-рт орж байгаа нь хүн амын эрүүл мэндийн боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Боловсролын салбарын хувьд хөдөөгийн сум, орон нутагт боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, төвийн сумдад цэцэрлэг, сургуулиудын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага байна. 2015 оны их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтад хамрагдагсдын шалгалтын дундаж оноогоор 21 аймгаас тэргүүлсэн нь боловсролын чанар сайн байгааг харуулж байна. Түүнчлэн орон нутгийн их, дээд болон техник мэргэжлийн сургуулиудын боловсон хүчний хангамж болон материаллаг баазыг сайжруулж, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлээр суралцагчдыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Аймгийн хөгжимт драмын театр, музей, номын сан болон түүх, соёлын дурсгалт газруудыг сэргээн засварлах, биет болон биет бус соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, улмаар соёл, урлагаар дамжуулан иргэдийн боловсрол, хүмүүжил, төлөвшлийг нэмэгдүүлэх хэрэгтэй юм.

#### **Аж үйлдвэрийн салбар:**

Уг салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. Бүтцээр авч үзвэл 2015 оны байдлаар 54.2 хувийг цахилгаан, дулаан үйлдвэрлэл, 26.3 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 13.4 хувийг уул уурхай, 6.1 хувийг ус хангамжийн салбар эзэлж байна. Аж үйлдвэр, барилгын салбарт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бага байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2015 онд 11.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн, эрчим хүч, дулаан, усан хангамжийн салбарт 26.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 37-40 хувиар тус тус өссөнөөр бусад аймгуудаас өндөр өсөлттэй байна.

Аж үйлдвэрийн салбарт зонхилох байрыг эзэлдэг Дорнод бүсийн Эрчим хүчний систем нь хүчин чадлынхаа дээд хэмжээг ашиглаж байгаа нь цаашид өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах үүднээс 100 мегаваттын өргөтгөлийн ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатайг харуулж байна. Дорнод аймгийн боловсруулах аж үйлдвэрийн салбарт нам болон технологигүй үйлдвэрлэл<sup>6</sup> зонхилж байна. Тиймээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр төрөл хэт цөөн, үйлдвэрлэлийн хэмжээ бага, мөн ДНБ-д боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хэмжээ доогуур, бүтээгдэхүүн нь зөвхөн дотоод зах зээлийг хангахад чиглэсэн, өрсөлдөх чадвар багатай байна.

Дорнод аймгийн аж үйлдвэрийн салбарт нэмүү өртөг бага шингэсэн эрчим хүч, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл давамгайлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарт

---

<sup>5</sup>[www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>6</sup>Олон улсын жишгээр үйлдвэрлэлийг өндөр, дундаж, нам технологитой ба бусад түүхий эдийн технологигүй гэж 4 ангилдаг.



гурил, зөгийн бал, цэвэр ус, архи, сүү, мах, махан бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн зэрэг хүнсний үйлдвэрлэл давамгайлж, гутал, савхин хүрэм зэрэг хувцас үйлдвэрлэлийн чиглэлийн цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, гол төлөв аймгийн болон дотоодын зах зээлд нийлүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байна. Тус аймагт ноос угаах үйлдвэр, хивсний үйлдвэр, хүнсний комбинат, тоосгоны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр зэрэг ашиглагдахгүй байгаа үйлдвэрүүдийн материаллаг баазад тулгуурлан хөнгөн, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөөц бололцоо байна.

#### **Хөдөө аж ахуйн салбар:**

Аймгийн ДНБ-ий 14.5 хувийг эзэлдэг. 2015 оны байдлаар 4043 малчин өрх байгаа нь аймгийн нийт өрхийн 18 хувийг эзэлж буй бөгөөд сүүлийн жилүүдэд малчин өрхийн тоо нэмэгдэж байна. Бусад аймгуудтай харьцуулахад сүрэгт ямааны эзлэх хувь харьцангуй бага бөгөөд 2015 оны эцсээр мал сүрэг өмнөх оныхоос 5 төрлөөр 11 хувиар өсөж, нийт 1.6 сая мал тоологдсоноос 126 мянган шилмэл омгийн мал тоологдсон. Илүү нугаламт барга хонь, үзэмчин хонь, сүү, махны чиглэлийн үхэр зэрэг шилмэл омгийн үүлдэрүүд мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж байна. Мөн сүүлийн жилүүдэд сүү, махны чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй болон гахай, шувуу, зөгийн туслах аж ахуйн үйлдвэрлэл нэмэгдсэн.

Буйр нуурын загасны аж ахуйд түшиглэн загас үржүүлэг, загасны махны үйлдвэр хөгжүүлэх боломжтой юм. Дорнод аймаг нь улсын хэмжээнд 1 га бэлчээрт ногдох малын тоо хамгийн бага, 1 га бэлчээрийн ургамлын ургац хамгийн өндөр аймгийн нэг бөгөөд цөлжилт, ган, зудын байгалийн гамшигт бага өртдөг зэргээрээ цаашид бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нөөц, давуу талтай юм.

Дорнод аймаг нь газар тариалангийн үйлдвэрлэлийн хамгийн их нөөцтэй аймгийн нэг бөгөөд улсын хадлангийн нийт талбайн 54 хувь, тариаланд тохиромжтой талбайн 22 хувь тус аймагт оршдог. Газар тариалангийн үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд сэргэж буй бөгөөд харьцангуй дулаан, чийглэг уур амьсгалтай, хөрсний үржил шим сайтай тул үр тариа болон хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, аймгийн хэрэгцээг бүрэн хангаж, илүүдэл бүтээгдэхүүнийг дотоодын хэрэгцээнд төдийгүй гадаад зах зээлд нийлүүлэх боломжтой. Цаашид гурилаас гадна нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үүднээс талх, нарийн боов, гоймон зэрэг гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, жимсний чанамал, шүүс, ургамлын тос, малын тэжээл, даршны үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломжтой.

#### **Уул уурхайн үйлдвэрлэл:**

Аж үйлдвэрийн салбарын 13 хувийг эзэлдэг. Дорнод аймаг нь газрын тос, уран, нүүрс, цайр, хар тугалга, төмрийн хүдэр, алт, зэс, молибден зэрэг эрдэс баялаг, барилгын үйлдвэрлэлийн түүхий эд болох шохойн болон барилгын чулуу, элс хайрга зэрэг ашигт малтмалын баялаг нөөцтэй. Аймгийн хэмжээнд нийтдээ 550 гаруй сая тн нүүрс болон 19, 21-р талбайн ашиглалтын баталгаат нийт 42.2 сая тн газрын тосны нөөцтэй. Хүрэн нүүрс нь илчлэг багатай, чийглэг тул экспортын өрсөлдөх чадвар бага бөгөөд нүүрсийг боловсруулж, эрчим хүч, илчлэг сайтай түлш, байгалийн хий гарган авах үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой.

Цаашид бүтээгдэхүүн хуваах гэрээгээр газрын тос болон бусад уул уурхайн үйлдвэрлэлээс аймаг, сумдад төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх, газрын тос олборлоход

хаягддаг хийг гарган авах зэрэг нэмүү өртөг шингэсэн дагалдах үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй юм. Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, шатахуун түлш болон дагалдах 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. Зүүн бүс, тэр дундаа Дорнод аймаг нь цайр, хар тугалга, кадми зэрэг өнгөт төмөрлөгийн нөөцөөр баялаг. Тухайлбал Улаан, Мухар, Цав зэрэг нөөц нь батлагдсан томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах үүднээс Сүхбаатар, Хэнтий аймгийн ордуудтай хамтатган кластерийн хандлагаар өнгөт металлургийн боловсруулах хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүнээ гадаадад нийлүүлэх боломжтой.

#### **Үйлчилгээний салбар:**

Дорнод аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд үйлчилгээний салбарын эзлэх хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр 2014 онд 18 хувь болж, аймгийн эдийн засгийн 2 дахь том салбар болсон. Үйлчилгээний салбар дотроо худалдаа, тээвэр зонхилох байрыг эзлэдэг. Гэвч тус салбарт бөөний болон жижиглэнгийн худалдаа давамгайлсан өрөөсгөл бүтэцтэй байгаа ба нэмүү үнэ цэнэ шингэсэн санхүүгийн үйлчилгээ, тээвэр ложистик, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, түрээс зэрэг үйлчилгээний бусад хэлбэрүүд төдийлөн хөгжиж чадаагүй. Хоёр улстай хиллэдэг, хилийн 6 боомттой, агаарын тээвэр, төмөр зам, автозамын сүлжээ сайн хөгжсөн болон Мэнэнгийн тал, Буйр нуур, Хөх нуур, Монгол Дагуур зэрэг байгалийн нөөц, Хэрлэнбарс хотын туурь, Халхголын дайны дурсгалт газрууд, буриад, барга, үзэмчин ястны түүх, соёлын нөөцдөө тулгуурлан гадаад болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой.

#### **Дэд бүтэц:**

Дорнод аймаг нь эрчим хүчний дотоодын найдвартай эх үүсвэрээр хангагдсан, агаарын тээвэр болон төмөр замаар олон улстай шууд холбогддоогоороо дэд бүтэц сайн хөгжсөн аймаг юм. Тээврийн салбарт зорчигч болон ачаа эргэлтээр автозамын тээвэр нь голлох үүрэгтэй бөгөөд Чойбалсан хот нь нийслэл Улаанбаатар хоттой 655 км, газрын тосны 19-р талбайгаас Халхгол сумын Баянхошуу боомт хүртэл 210 гаруй км хатуу хучилттай замаар холбогдсон. Цаашид Мянганы замын хэвтээ болон босоо тэнхлэгийн дагууд, аймгийн төвөөс хилийн боомтууд хүртэл, мөн аймгийн доторх улсын чанартай замуудыг үе шаттайгаар хатуу хучилттай болгон барихаар төлөвлөгдсөн. Чойбалсан хотоос Эрэнцавын боомтоор дамжин ОХУ-тай төмөр замаар холбогдсон бөгөөд энэ замаар Зүүн Ази, Европтой болон хамгийн ойр далайд гарах 5-6 гарцуудтай шууд холбогдох боломжтой. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасны дагуу Бичигт-Хөөт, Баруун-Урт-Хөөт-Чойбалсан болон Чойбалсан-Нөмрөг чиглэлийн төмөр замыг байгуулснаар гадаадтай төмөр замын 3 чиглэлээр шууд холбогдож, олон улсын төмөр замын томоохон зангилаа болж хөгжих боломжтой. Чойбалсан хот нь агаарын тээврийн хувьд олон улсын зангилаа хот болох бөгөөд Чойбалсан хотын олон улсын нисэх онгоцны буудал нь дотоодын нислэгээс гадна Манжуур, Хайлаар чиглэлд олон улсын шууд нислэг үйлдэж байна. Цаашид Чойбалсан-Халхгол, Чойбалсан-Эрэнцав чиглэлд дотоодын, мөн Чойбалсан-Рашаант, Чойбалсан-Чита чиглэлд гадаадын тогтмол шууд нислэгийг хийж, аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих боломжтой.

# ДӨРӨВ. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ХӨГЖЛИЙН ЭХ СУРВАЛЖ, БОЛОМЖУУД

## ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

*Дорнод аймагт нийгэм, эдийн засгийн шийдвэрлэх шаардлагатай дараах тулгамдсан асуудлууд оршин байна.*

1. Дорнод аймагт хүн амын төрөлт нэмэгдэж, нас баралт буурч байгаа боловч иргэдийн гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн их байгаатай холбоотойгоор хүн амын тоо буурах хандлагатай байна.
2. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар өндөртэй иргэд ажил, амьдралын баталгаа илүүтэй төв суурин газар, нийслэл хот, гадаад оронд татагдаж байгаа нь аймаг, сумын бүтээх чадвар хоцрогдох, хөгжлийн бодлогын чиглэлүүдэд шаардлагатай мэргэжилтэн, хүний нөөцөөр дутагдахад хүргэж байна. Түүнчлэн өндөр хөгжилтэй гадны орнуудад болон нийслэл, бусад бүс нутагт ажиллаж, амьдарч байгаа Дорнод аймгийн уугуул иргэдийнхээ мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог ашиглах шаардлага ч гарч байна.
3. Аймгийн хүн амын дунд 2030 он гэхэд нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин буурч, хүүхдийн болон ахмад настны ачаалал нэмэгдэхээр байгаа нь нэг талаар сургууль, цэцэрлэгийн хэрэгцээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарыг бэхжүүлж, уг салбарт шаардлагатай төсөв, хөрөнгийн суурийг одооноос бий болгоход анхаарах шаардлагатайг харуулж байна.
4. Нас баралтын түвшин улсын дунджаас дээгүүр, мөн хүн амын дундаж наслалтаар улсын хэмжээнд аймгуудаас 19-р байрыг эзэлж байгаа нь гол төлөв амьдралын буруу хэвшил, дадлаас үүдэлтэй байна.
5. Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн түвшин нь дэлхийн уур амьсгалын дулаарлын хурдацтай өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул, зах зээлд өрсөлдөх чадавхи бага байгаа нь уг салбарт хөдөлмөр эрхлэгчдийн амьдрах нөхцөл, ажиллах орчин доройтох, улмаар дотоодын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.
6. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүдээс авах байгалийн баялаг ашигласны нөхөн төлбөрийг бодитоор үнэлүүлж авч чадахгүй, тэдгээр аж ахуйн нэгжүүдийн орон нутагт оруулах хувь нэмэр чамлалттай байгаа нь байгалийн баялгаа ашиглуулсан ч эдийн засгийн өсөлт, хөгжлийн дэвшилгүй хоцорч болзошгүй эрсдлийг дагуулж байна.
7. Өнөөгийн эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нь цаашид өсөн нэмэгдэх цахилгаан, дулааны эрчим хүчний эрэлтийг хангах боломжгүй түвшинд байгаа нь орон нутагт төлөвлөгдсөн томоохон бүтээн байгуулалтын ажлуудад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

## ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЭХ СУРВАЛЖ, БОЛОМЖУУД

*Дорнод аймагт эдийн засаг, нийгмийн хөгжлийн цэгцтэй, цогц бодлого хэрэгжүүлэх дараах эерэг нөхцөлүүдийг хөгжлийн эх сурвалж гэж үзнэ.*

1. Дорнод аймгийн ажиллах хүчний 60 орчим хувь нь 15-аас 39 насны залуучууд байгаа бөгөөд Зүүн бүсийн хамгийн том “Дорнод” их сургууль, политехникийн коллеж, мэргэжил, сургалтын төвүүдэд түшиглэн аймгийн болон үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтад шаардлагатай дотоодын мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх боломжтой.
2. Хөдөө аж ахуйн баялаг нөөц нь Дорнод аймгийг зүүн бүс, улс орны хэмжээнд төдийгүй, бүс нутгийн хүрээнд хадлан тэжээл, эко-органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төв болох боломжийг олгож байна. Дорнод аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчээр хангагдаж, зарим бүс нутагт нөөц хүчин чадал бий болж байгаа нь орон нутагт орчин үеийн технологид суурилсан хөдөө аж ахуйн жижиг, дунд үйлдвэр байгуулж, хөгжүүлэх боломжийг олгож байна.
3. Дорнод аймаг нь газрын тос, өнгөт төмөрлөг, хүрэн нүүрс зэрэг байгалийн ховор ашигт малтмалын баялаг нөөцдөө тулгуурлан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар боловсруулах аж үйлдвэрийн томоохон цогцолбор байгуулах замаар хагас болон гүн боловсруулсан, технологи шингээсэн, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнээр үндэсний хэмжээнд төдийгүй олон улсад өрсөлдөх бололцоо бий.
4. Эдийн засгийн хурдацтай өсөлтийн нөлөөгөөр БНХАУ-ын өндөр орлоготой болон дундаж давхаргын иргэдийн тоо өсч, аялал жуулчлал, амралт, сувиллын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдэж байна. Дэлхийд ховордсон байгалийн өвөрмөц экосистем, түүх, дурсгал, соёлын өлгий нутаг Дорнод аймаг нь газарзүйн байршлын давуу талдаа тулгуурлан гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай боломж бүрдээд байна.
5. Монгол Улсын гадаад харилцаанд нэн таатай ахиц гарч, хөрш хоёр оронтой харилцаа, хамтын ажиллагаагаар иж бүрэн стратегийн түншлэлд хүрсэн. Түүнчлэн хөрш орнуудын хамтын ажиллагаа эрчимжиж байгаа өнөө үед хил залган оршдог ОХУ, БНХАУ-ын мужуудын худалдаа, үйлдвэрлэлийн сүлжээнд нэгдэх, бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх тээвэр, ложистикийн томоохон төв болон хөгжих боломжийг олгож байна.
6. Монгол Улсын “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан Чойбалсан-Хөөт-Бичигтын боомт хүртэлх босоо тэнхлэгийн, Хөөт-Матад-Тамсагбулаг-Сүмбэр боомт хүртэлх хэвтээ тэнхлэгийн төмөр зам ирэх жилүүдэд баригдана. Түүнчлэн Чойбалсан-Эрэнцав чиглэлийн төмөр замын ашиглалтыг нэмэгдүүлэх замаар Азийн төмөр замын нэгдсэн сүлжээнд холбогдон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг Зүүн хойд Азийн зах зээлд нийлүүлэх боломж бүрдэнэ.

## **ТАВ. ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА**

*“Дорнод аймаг нь бүтээх чадвартай, аз жаргалтай иргэдтэй, мэдлэгт суурилсан, унаган байгаль экологийн тогтвортой байдлаа хадгалсан хөдөө аж ахуй, уул уурхай, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэл бүхий олон тулгуурт эдийн засагтай, улсын хөгжилд тэргүүлэх үүрэгтэй аймаг болоход оршино”.*

### **Агуулгын хамрах хүрээ:**

Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр” тунхаглалын үзэл санааны хүрээнд боловсруулсан.

### **Орон зайн хамрах хүрээ:**

Хөгжлийн хэтийн зорилтыг Дорнод аймгийн нийт нутаг дэвсгэр, аймгийн төв болон бүх сумдыг хамруулан хэрэгжүүлэх бөгөөд нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг тооцон, бүсийн хоёр аймгийн хөгжлийн хэтийн зорилттой уялдуулан ажиллана.

### **Хугацааны хамрах хүрээ:**

Хөгжлийн зорилтыг дараах 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- *Нэгдүгээр үе шат.* 2016-2020 онд хөгжлийн зорилтуудад хүрэхэд зайлшгүй шаардагдах урьдач нөхцөл, чадамжийг бүрдүүлж, салбар хоорондын уялдааг ханган чанартай, тэгш, хүртээмжтэй тогтолцоог бий болгоно.
- *Хоёрдугаар үе шат.* 2021-2025 онд эдийн засаг, зах зээлээ төрөлжүүлэх, өндөр ур чадвар, бүтээх чадамж бүхий ажиллах хүчийг бий болгох, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, бүтээмжийг өсгөх замаар үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж үндэсний түвшинд өрсөлдөх чадварыг бий болгон хөгжлийг эрчимжүүлнэ.

## ЗУРГАА. ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Дорнод аймгийн хөгжлийн бодлогын чиглэлүүдийг тодорхойлохдоо уул уурхай болон хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл гэсэн бодлогын хоёр тэргүүлэх чиглэлийг сонгож, хөгжүүлэхэд түлхүү анхаарснаар нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын бусад чиглэлүүдийн хөгжилд шууд болон дам байдлаар эерэгээр нөлөөлж, баялгийн хуримтлал, хөгжлийн нөөцийг бий болгох зарчимд тулгуурласан.

ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ	БОДЛОГЫН ЧИГЛЭЛҮҮД	ЗОРИЛТ
ХҮН ТӨВТЭЙ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАЖ, ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.	<p><b>Бодлогын чиглэл 1.</b> Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний чанартай, тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж, хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, дэвшилтэт технологи, удирдлага менежментийн шилдэг тогтолцоог нэвтрүүлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэн хүн амын өсөлтийг дэмжинэ.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг олон улсын стандартад хүргэж, хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаа голлох өвчлөлийн түвшинг улсын дунджаас бууруулна.</li> <li>2. Эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхитэй оролцоог нэмэгдүүлнэ.</li> <li>3. Гэр бүлийг нийгмийн анхдагч орчин, ирээдүй хойч үеийн эрүүл саруул өсч бойжих, эх орноо хайрлах үзэл, ёс зүй, уламжлалт соёл, арга ухааныг өвлөн авч хүмүүжих суурь орчин болгон хөгжүүлнэ.</li> <li>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэд, Залуучууд, Эмэгтэйчүүд, Ахмад настан зэрэг хүн амын зорилтот бүлэгт чиглэсэн бодлого боловсруулан хэрэгжүүлж, тэдэнд ээлтэй төрийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.</li> </ol>
	<p><b>Бодлогын чиглэл 2.</b> Үндэсний болон орон нутгийн онцлогийг хадгалсан, аймаг, бүс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тэтгэсэн боловсролын байгууллагын тогтолцоог хөгжүүлж, бие даасан байдлыг нь дэмжинэ.</p>	<ol style="list-style-type: none"> <li>5. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлж үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.</li> <li>6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл, аюулгүй ажлын байртай, орлоготой, бүтээлч иргэдийг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлж, гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулж, ядуурлыг бууруулна.</li> </ol>
	<p><b>Бодлогын чиглэл 3.</b> Аймгийн засаглалын чадавхийг бэхжүүлж, хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулна.</p>	<ol style="list-style-type: none"> <li>7. Орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлж, төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулна.</li> <li>8. Орон нутгийн хөгжилд өгөөжтэй, хариуцлагатай, ил тод уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</li> </ol>
ОЛОН ТУЛГУУРТ, ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГАЙ, ТЭРГҮҮЛЭХ ХӨГЖИЛТЭЙ АЙМАГ БОЛНО.	<p><b>Бодлогын чиглэл 4. (Тэргүүлэх чиглэл).</b> Хөдөө аж ахуйн баялаг нөөцөд тулгуурлан эко-органик, технологи шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</p>	<ol style="list-style-type: none"> <li>9. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүс нутгийн онцлог, уламжлалт чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж, мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.</li> <li>10. Газрын баялаг нөөцөд тулгуурлан, хөрсний үржил шимд сөргөөр нөлөөлөхгүй, нэгж талбайгаас хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх дэвшилтэт технологид тулгуурлан импортыг орлож, экспортод чиглэсэн газар тариаланг хөгжүүлнэ.</li> <li>11. Хүнсний болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг гүн боловсруулах хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ.</li> </ol>
	<p><b>Бодлогын чиглэл 5 (Тэргүүлэх чиглэл).</b> Уул уурхайн</p>	<ol style="list-style-type: none"> <li>12. Газрын тос, нүүрс, өнгөт төмөрлөг болон барилгын материалын боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж,</li> </ol>

	<p>боловсруулах болон барилгын материалын үйлдвэрлэлийг кластерийн хандлагаар хөгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ.</p>	<p>бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлснээр аймгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.</p>
	<p><b>Бодлогын чиглэл 6.</b> Газарзүйн байршлын давуу талдаа тулгуурлан эрчим хүч, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, Монгол Улсын төвийн бүс болон хөрш орнуудыг холбосон дэд бүтцийн зангилаа төв болно.</p>	<p>13. Байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй технологид суурилсан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аймгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж, илүүдэл эрчим хүчээ экспортолно.</p> <p>14. Орчин үеийн ложистик, зам тээврийн дэд бүтцийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засагт интеграцлагдах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>15. Орчин үеийн мэдээлэл, харилцаа, холбооны дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл холбооны үйлчилгээг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.</p>
	<p><b>Бодлогын чиглэл 7.</b> Байгалийн болон түүх, соёлын нөөцөд тулгуурлан дотоод, гадаад аялал жуулчлал, дагалдах үйлчилгээний салбар, дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлнэ.</p>	<p>16. Аялал жуулчлалын салбарын мэдээллийн хүртээмжийг сайжруулж маркетинг, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх замаар жуулчдын тоог өсгөж, Зүүн Хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.</p> <p>17. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсронгуй болгон бусад салбартай уялдуулан хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.</p>
	<p><b>Бодлогын чиглэл 8.</b> ОХУ, БНХАУ-ын хил залгаа мужууд, Зүүн Азийн орнуудтай харилцан ашигтай гадаад худалдаа, идэвхитэй хамтын ажиллагааг өргөжүүлж, Зүүн Хойд Азийн интеграцид нэгдэн тээвэр, ложистик, худалдааны томоохон төв болно.</p>	<p>18. Хил залгаа мужууд, Зүүн Хойд Азийн орнуудтай тогтоосон найрсаг хамтын ажиллагаагаа өргөжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчдийг татах чиглэлд “санаачилгатай” ажиллаж, аймгийн тэргүүлэх салбаруудын хөгжлийг дэмжинэ.</p>
	<p><b>Бодлогын чиглэл 9.</b> Хөгжлийн нөөц, онцлог, давуу талдаа тулгуурлан сумдыг бүсчилсэн хөгжлийн хандлагаар хөгжүүлнэ.</p>	<p>19. Хөгжлийн нөөц, давуу тал болон нийгэм-эдийн засгийн таталцалд тулгуурлан аймгийн сумдыг бүсчилсэн хөгжлийн зарчмаар Өмнөд, Төвийн, Баруун хойд, Зүүн хойд гэсэн 4 бүсээр хөгжүүлнэ.</p>
<p><b>ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.</b></p>	<p><b>Бодлогын чиглэл 10.</b> Байгалийн баялгийн нөөцийг түүний нөхөн сэргэх чадавхид нь тохируулан ашиглаж, тогтвортой хөгжлийг хангах замаар байгалийн унаган төрхийг хадгална.</p>	<p>20. Хүрээлэн буй орчны бохирдуулыг бууруулахад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг багасгана.</p> <p>21. Хамгаалалтад авах шаардлагатай экосистем, биологийн чухал ач холбогдолтой газруудыг улсын тусгай хамгаалалтад авна.</p> <p>22. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөгжлийг хангана.</p>
	<p><b>Бодлогын чиглэл 11.</b> Иргэдийн суурь хэрэгцээг бүрэн хангасан, амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хот сууринг хөгжүүлнэ.</p>	<p>23. Ус, дулаан хангамж, ариутгах татуургын найдвартай байдлыг хангаж, хүн амын тохитой, цэвэр орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>24. Үлгэр жишээ ухаалаг, ногоон хот, сууринг байгуулж, хүн амын тохитой амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>

## ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ 1: ХҮН ТӨВТЭЙ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАЖ, ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 1. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТАЙ, ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ОНОВЧТОЙ БОДЛОГО, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, УДИРДЛАГА МЕНЕЖМЕНТИЙН ШИЛДЭГ ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР ДУНДАЖ НАСЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭН ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИНЭ.**

**Зорилт 1.** Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг олон улсын стандартад хүргэж, хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаа голлох өвчлөлийн түвшинг улсын дунджаас бууруулна.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Эрүүл мэндийн байгууллагыг чадавхижуулж, хүний нөөцийг бэхжүүлэх замаар нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх алхам.*

### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 1.1. Хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судлах, хянах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл ахуйг сахиулах, халдварт өвчлөлийн тандалт судалгаа хийх, дархлаажуулах, эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах чиг үүрэг бүхий нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулж, үйл ажиллагааг нь хэвшүүлнэ.
- 1.2. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд компьютерт томографийн аппарат, рентген аппарат, уян дуран, ЭХО аппарат зэрэг тоног төхөөрөмжийг суурилуулж, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3. Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хорт хавдар, бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэг эрт илрүүлэх бололцоог олгох лабораторийн урвалж, оношлуур, дүрс оношилгооны багаж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 1.4. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч, сувилагчдын тоог стандартад хүргэж, нэг эмч, сувилагчид ноогдох ачааллыг бууруулах замаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлнэ.
- 1.5. Дотоод, гадаадын их, дээд сургууль болон хил залгаа улсуудын эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд нарийн мэргэшсэн эмч, эмнэлгийн ажилтнуудыг шинээр бэлтгэж, бүх шатны эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулна.
- 1.6. Сум, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байран дээр дадлагажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 1.7. Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс орон сууцжуулах, малжуулах, хязгаар, бүсийн нэмэгдэл олгох зэрэг нийгмийн хангамжийг сайжруулахад чиглэсэн ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.



- 1.8. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг өндөр хурдны интернэт, орчин үеийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг эрчимжүүлж, зайн оношилгоог нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.9. Уламжлалт анагаах ухааны төвийн тусламж үйлчилгээг байгалийн гаралтай эмчилгээний төрлөөр өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 1.10. Сүрьеэ болон бэлгийн замын халдварт өвчлөлийг бууруулах, үзлэг оношилгоо, эмчилгээний тогтмолжуулах өвчлөлийн түвшинг улс, бүсийн дунджид хүргэнэ.
- 1.11. Цэцэрлэг, сургуулийн эмч, сувилагч нарыг амны хөндийн эрүүл ахуйн сургалтад хамруулах, амны хөндийн эрүүл ахуйч ажиллуулах замаар шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он): Дэвшилтэт технологи, менежментийн шилдэг арга барилыг нэвтрүүлэх замаар эрүүл мэндийн үйлчилгээгээр тэргүүлэх аймаг болох алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 1.12. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүн амын эрүүл мэндийн нэгдсэн цахим мэдээллийн сан, цахим үйлчилгээг нэвтрүүлж “Цаасгүй эмнэлэг” болгон хөгжүүлнэ.
- 1.13. Гар утас, мэдээллийн технологид тулгуурлан иргэд эмнэлгийн үйлчилгээний тухай мэдээллийг онлайнаар авах, эмчид цаг захиалах, үйлчилгээний чанарыг дүгнэх бололцоог олгож, эмнэлгийн үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байдлыг хангана.
- 1.14. Аймгийн нэг сувилагч, их эмчид ноогдох өвчтөний тоогоор улсын дунджид хүрнэ.
- 1.15. Зайн оношилгоог ашиглах замаар Үндэсний төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг нэвтрүүлж алсын зайн оношилгоо, эмчилгээний үндэсний сүлжээнд нэгдэнэ.
- 1.16. Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийг бохир, цэвэр усны нэгдсэн системд бүрэн холбож эрүүл мэндийн үйлчилгээний стандарт, шаардлагыг хангасан орчинг бүрдүүлнэ.
- 1.17. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд олон улсын чанарын удирдлагын ISO стандартыг нэвтрүүлнэ.
- 1.18. Зүүн бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн иж бүрэн тоноглогдсон техник, тоног төхөөрөмж, машин хэрэгсэл бүхий яаралтай тусламжийн төвийг байгуулна.
- 1.19. Онцгой байдлын үеийн эм хангамж, хувцас, тоног хэрэгслийн нэн шаардлагатай нөөцийн санг бүх сумдад бий болгоно.
- 1.20. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачаалал хуваалцах, өндөр технологи бүхий тоног төхөөрөмж нэвтрүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.21. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний төвийг бүсийн уламжлалт анагаах ухааны төв болгон өргөжүүлж байгалийн болон уламжлалт эмчилгээний төрөлжсөн үйлчилгээтэй, хөрш орнуудын эрүүл мэндийн байгууллагуудтай нягт хамтын ажиллагаатай анагаах ухааны төв болгон өргөжүүлэн хөгжүүлнэ.

- 1.22. Бүх сумдын цэцэрлэг, сургуулиудыг шүдний эмч, кабинетаар хангах замаар амны хөндийн өвчлөлийг улсын дунджаас бага түвшинд хүргэж бууруулна.

Зорилт 2. Эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхитэй оролцоог нэмэгдүүлнэ.

*Бүх үе шатанд (2016-2025 он): Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 2.1. Сэтгэлзүйн болон эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн эрүүл мэндийн кабинетуудыг сум дундын болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн байгуулна.
- 2.2. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлт зан үйлийг өөрчлөхүйц эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.3. Хүүхдүүдийг бага наснаас эхлэн бие бялдрыг нь чийрэгжүүлэн дархлаажуулах, эрүүл мэндийн зөв зан үйлд төлөвшүүлэх, хүүхдийн амны хөндийг эрүүл байлгахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.4. Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх спортын дугуйлан, клубуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар бүх нийтийн биеийн тамир, спортын хөдөлгөөн өрнүүлнэ.
- 2.5. Эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн эмнэлгийн анхны тусламжийн мэдлэг олгох сургалтыг байгууллага, аж ахуйн нэгжид тогтмол явуулж хэвшүүлнэ.
- 2.6. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л аж ахуйн нэгжүүдэд жил бүр ажиллагчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох, эрүүл ажлын байр бий болгох шаардлагыг тавьж, хорт хавдар, сүрьеэ, чихрийн шижин, зүрх судас, бөөр, элэг, бэлгийн замын халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх бололцоог олгоно.
- 2.7. Иргэдийн эрүүл мэндээ бэхжүүлэхэд чиглэсэн идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх нийтийн биеийн тамирын талбай, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулсан иргэд, аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтыг тэдний нэрэмжит болгон алдаршуулах, олон нийтэд сурталчлахыг дэмжинэ.
- 2.8. Эмийн тухай үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэх, эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгож, эмийн бус эмчилгээний аргыг таниулж сурталчилна.
- 2.9. Эмийн худалдаанд тавигдах хяналт, шаардлагыг өндөржүүлж, жорын бичилтгүй эмийн худалдааг бууруулах талаар арга хэмжээ авна.
- 2.10. Архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах талаар сургалт сурталчилгаа явуулж буй төрийн бус байгууллагуудыг дэмжиж, энэ чиглэлээр төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилт 3. Гэр бүлийг нийгмийн анхдагч орчин, ирээдүй хойч үеийн эрүүл саруул өсч бойжих, эх орноо хайрлах үзэл, ёс зүй, уламжлалт соёл, арга ухааныг өвлөн авч хүмүүжих суурь орчин болгон хөгжүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн эрүүл, таатай орчинг бүрдүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 3.1. Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн судалгааг холбогдох яам, улсын Бүртгэл, статистикийн ерөнхий газартай хамтран баталсан аргачлалын дагуу 3 жилд нэг удаа аймгийн хэмжээнд зохион байгуулна.
- 3.2. Хүүхдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, соёл уламжлал, ёс заншлыг өвлүүлэх бүтээлч орчин бий болгох зорилгоор Чойбалсан хотод хүүхдийн ордон байгуулна.
- 3.3. Гэр бүлийн хөгжил, тогтвор суурьшилтай амьдрал, өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.4. Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах бололцоог нэмэгдүүлэх замаар хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг олгож, эцэг, эхчүүдэд хөдөлмөр эрхлэх бололцоог нэмэгдүүлнэ.
- 3.5. Хүүхэд, гэр бүлийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хүүхдийн хөгжлийн төв, гэр бүлийн боловсролын төвийг сумдад байгуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.
- 3.6. Томоохон үзвэр, үйлчилгээний газруудад бага насны хүүхэд хуурайлах, саатуулах, тоглох өрөө байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 3.7. Орон нутгийн телевизийн хөтөлбөрүүдэд хүүхэд, гэр бүлийн боловсролыг дэмжихэд чиглэсэн нэвтрүүлгийн эзлэх хувийг нэмэгдүүлж нийт хөтөлбөрийн 20-оос доошгүй хувьд хүргэнэ.
- 3.8. Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаар сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулна.
- 3.9. Хүүхэд, залуучуудын нөхөн үржихүй, эрүүл мэндийн боловсролыг дэмжих зорилгоор охидын кабинет байгуулж, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээг үе тэнгийн сургагчдаар дамжуулан хэрэгжүүлнэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он): Гэр бүлд ээлтэй нийгмийн орчин бүрдүүлж, хүний хөгжлөөр тэргүүлэх аймаг болох алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 3.10. Иргэд хорших, дундын хуримтлалын сан үүсгэх замаар орон сууцтай болох санаачилга, үйл ажиллагааг дэмжинэ.
- 3.11. Чойбалсан хотод иргэдийн соёлын хэрэгцээг хангах орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий кино театрыг хувийн хэвшлийн хөрөнгөөр байгуулахыг дэмжинэ.
- 3.12. Эрүүл чийрэг бие бялдартай, эх оронч, бүтээлч хариуцлагатай, амьдрах ухаанч, бие даах чадвартай хүүхэд, өсвөр үеийнхнийг төлөвшүүлэх зорилготой Хөдөлмөр амралтын зуслан байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 3.13. Гэр бүл, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх байнгын үйл ажиллагаатай парк, цэцэрлэгт хүрээлэнг сумдад үе шаттайгаар байгуулна.

- 3.14. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эх нялхсын эрүүл мэндийн сувилал, асаргааны төв байгуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.15. Орон нутгийн телевизийн хөтөлбөрүүдэд хүүхэд, гэр бүлийн боловсролыг дэмжихэд чиглэсэн нэвтрүүлгийн эзлэх хувийг нэмэгдүүлж нийт хөтөлбөрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ.
- 3.16. Орон нутгийн театрт түшиглэн хүүхдэд зориулсан хүүхэлдэйн театрыг байгуулна.
- 3.17. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалж, олон улсын стандартад нийцсэн Хохирогчийг хамгаалах байрыг өргөтгөж ашиглана.

Зорилт 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэд, Залуучууд, Эмэгтэйчүүд, Ахмад настан зэрэг хүн амын зорилтот бүлэгт чиглэсэн бодлого боловсруулан хэрэгжүүлж, тэдэнд ээлтэй төрийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нийгмийн зорилтот бүлгүүдэд нийгмийн харилцаанд бусадтай адил тэгш оролцох, төрийн үйлчилгээг саад бэрхшээлгүй авах нөхцөл, бололцоогоор хангах ажлыг эрчимжүүлэх алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 4.1. Залуучуудыг номтой нөхөрлүүлэх, мэдээлэл авах, бие даан суралцахад дэмжлэг үзүүлэх Залуучуудын хөгжлийг дэмжих төвийг хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд сум бүрт байгуулна.
- 4.2. Амьдралын зорилготой, тодорхой орлоготой залуучуудыг орон сууцтай болох, мэргэжил эзэмших сургалтад хамруулах, хувийн аж ахуй эрхлэх боломж бүхий зээл болон тэтгэлэгт хамруулах зэргээр дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь тусална.
- 4.3. Асрамжийн төвөөс 18 нас хүрээд гарч буй хүүхдүүдэд цаашид бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэн гэр олгох, амьдралын гарааны нэг удаагийн санхүүгийн дэмжлэг болон сургалтын төлбөрийн туслалцаа үзүүлнэ.
- 4.4. Залуу малчдыг бэлтгэх, залуу үеийн мал аж ахуй эрхлэх сонирхлыг бий болгох зорилгоор малчдын мал аж ахуй эрхлэх, экологийн өөрчлөлтөд дасан зохицох, байгаль орчноо хамгаалах, мэдээлэл авах, орчин үеийн технологийг мал аж ахуйд хэрэглэх сургалтын иж бүрэн тогтолцоог төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор бий болгоно.
- 4.5. Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.6. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулж санаачлагч, зөвлөн туслагч, баялаг бүтээгч болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.7. Ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын бүтээгдэхүүний худалдан авалтыг аялал жуулчлал, үйлчилгээний салбартай уялдуулан бодлогоор дэмжинэ.
- 4.8. Аймгийн төв, сумдын төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын гадаад, дотоод орчныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байхаар тохижуулж, тэднийг

нийгмийн харилцаанд бусадтай адил тэгш оролцох, төрийн болон бусад үйлчилгээг саад бэрхшээлгүй авах нөхцөл, бололцоогоор хангана.

- 4.9. Олон улсын стандартад нийцсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төв, тэдний насны онцлогт тохирсон тоноглол бүхий чийрэгжүүлэлт, нөхөн сэргээх төвийг байгуулна.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он): Нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 4.10. Залуу гэр бүлийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн хүүхэд асрах, халамжлах, хөгжүүлэх үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгосон байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг арга зүйн болон санхүүгийн дэмжлэгээр хангана.
- 4.11. Ахмад настны эрүүл мэндийг урьдчилан хамгаалах, амралт, сувиллын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ганц бие ахмад настныг асран халамжлах хөгжлийн үйлчилгээний төвийг байгуулна.
- 4.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношлох, бүртгэх, сэргээн засах үйл ажиллагааны чанар, хүртээмжийг олон улсын донор байгууллагын тусламжтайгаар нэмэгдүүлнэ.
- 4.14. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хэрэгцээнд тохирсон тоноглол бүхий чийрэгжүүлэлт, нөхөн сэргээх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 2. ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ОНЦЛОГИЙГ ХАДГАЛСАН, АЙМАГ, БУС, ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ТЭТГЭСЭН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЖ, БИЕ ДААСАН БАЙДЛЫГ НЬ ДЭМЖИНЭ.**

Зорилт 5. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлж, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Хүүхэд, залуусын сурч хөгжих эрсдэлгүй, эрүүл таатай орчныг нэмэгдүүлж, багшийг тасралтгүй хөгжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 5.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд хүүхдэд уламжлалт зан заншил, өв соёл, эх түүхээрээ бахархдаг, эх оронч сэтгэлгээтэй, өөрийн гэсэн үнэт зүйлтэй болох төлөвшил, хөгжлийг дэмжсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хөтөлбөртөө тусган хэрэгжүүлнэ.
- 5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийнхнийхээ дунд сурч, хөгжих, найзалж нөхөрлөх боломжийг нэмэгдүүлэхэд, шинээр баригдах сургууль, цэцэрлэгт орц, гарц,

- ариун цэврийн байгууламж, ширээ сандал, сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- 5.3. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөлт ажлуудыг зохион байгуулна.
  - 5.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудыг халаалт, бохир, цэвэр усны нэгдсэн системд холбох, ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу болгох ажлыг шат дараатайгаар эхлүүлнэ.
  - 5.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг камержуулж, хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлнэ.
  - 5.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг өндөр хурдны интернетэд бүрэн холбож, цахим сургалтын систем, номын сан, мэдээллийн сантай болгоно.
  - 5.7. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлж, хүүхдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.
  - 5.8. Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулиуд, хүн ам ихтэй сумдын сургуулийг хүүхдийн автобустай болгоно.
  - 5.9. Сум, багийн багш нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
  - 5.10. Боловсролын бүх шатны багшлах боловсон хүчний нөөцийг олон улсын жишигт нийцүүлэн бэлтгэх, хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
  - 5.11. Хувийн хэвшлийн цэцэрлэг, сургууль олноор байгуулахыг дэмжинэ.
  - 5.12. Нэг багш, нэг бүлэгт ногдох хүүхдийн тоог стандарт жишигт хүргэхийн тулд цэцэрлэг, сургуулийг өргөтгөх шинээр барих ажлыг эрчимтэй зохион байгуулна. бууруулна.
  - 5.13. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг сайжруулж, сургуулийн нийгмийн ажилтнуудыг ажил мэргэжлийн зөвлөхийн сургалтад хамруулж чадавхжуулна.
  - 5.14. Албан бус, насан туршийн боловсролын төвийг аймгийн төвд, сумдад нэгжийг байгуулж, 16-35 насны иргэдийн хэрэгцээнд нийцсэн гэр бүл, ёс суртахуун - төлөвшил, гоо зүй-мэдрэмж, иргэний боловсрол, амьдрах ухааны чадварыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он): Боловсролын салбарын бүтээмж, чадамжийг бэхжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 5.15. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, аймаг, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан, цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалттай бие даасан ахлах сургуулиудтай болно.
- 5.16. Хүүхэд бүр үндсэн, цагийн, улирлын, ээлжийн, явуулын, багшийн, нүүдлийн зэрэг хэлбэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 100 хувь хамрагдсан байна.
- 5.17. Ерөнхий боловсролын сургуулиуд нэг ээлжээр хичээллэх боломж бүрдсэн байна.
- 5.18. Ерөнхий боловсролын сургуулиуд дахь байгалийн ухааны лаборатори, зохион бүтээх төвийн тоог нэмэгдүүлнэ.
- 5.19. Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн цахим системийг салбарын хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна.
- 5.20. Цэцэрлэг, ЕБС, МСҮТ, их дээд сургууль хоорондын болон гадаад харилцаа, хамтын ажиллагааг дэмжинэ.

- 5.21. Политехникийн коллежийг түшиглэн хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэж, ажлын байраар хангах хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 5.22. Үндэсний болон гадаадын их, дээд сургуулиудад хөдөө аж ахуй, аялал жуулчлал, уул уурхай, өнгөт металлург зэрэг аймгийн хөгжлийн Бодлогын чиглэлээр болон биотехнологи, хими технологи, төмөрлөгийн боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн инженерийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэхэд түлхүү анхаарна.
- 5.23. Иргэн бүрт насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл боломжийг бүрдүүлэн, бүх шатны боловсролын нээлттэй болон зайны сургалтын төв байгуулж ажиллуулах
- 5.24. Дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчдыг суралцах хугацаанд нь үйлдвэрлэлийн болон шаардлагатай бусад чиглэлээр дадлагажуулах замаар бие даан ажиллах чадвартай ажиллах хүчийг бэлтгэхэд сургалтын байгууллага, үйлдвэр, хувийн хэвшлийн хамтран ажиллахыг дэмжинэ.

Зорилт 6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл, аюулгүй ажлын байртай, орлоготой, бүтээлч иргэдийг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлж, гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулж, ядуурлыг бууруулна.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шилжилт хөдөлгөөнийг бууруулах суурь нөхцөлийг бий болгох алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 6.1. Аймгийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болох хөдөө аж ахуй, уул уурхай, өнгөт төмөрлөгийн салбарт шаардлагатай мэргэжлээр өндөр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллах ажлын байр, орон сууц, амьдралын нөхцөлөөр хангаж, гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулна.
- 6.2. Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллагчдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгож, хэвшүүлнэ.
- 6.3. Шинээр бий болсон, төлөвлөгдөж буй ажлын байруудад шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний эрэлтийн судалгааг тогтмол хийж, орон нутгийн их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг хангаж, энэ чиглэлээр жил бүр ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг зохион байгуулна.
- 6.4. Залуу малчдад мал маллах арга ухаан болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах болон хүнсний ногоо тариалахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.5. Орлого багатай болон хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг ажлын байр, түрээсийн хөнгөлөлт болон орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээнд давуу эрхтэйгээр нийлүүлэх бодлогоор дэмжинэ.
- 6.6. Аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулахад төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажиллана.

- 6.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох, аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.8. Мэргэжилтэй залуучууд, төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ажил, мэргэжилд зуучлах, эзэмшсэн мэргэжлээрээ бизнес, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, мөн оюутнуудад суралцах хугацаандаа ажил хөдөлмөр хийж туршлагажих, орлого олоход нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 6.9. Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдэд жижиг зээл олгох, бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлэх, аж ахуй эрхлэлтийн мэдлэг эзэмшүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, албан хэлбэрт шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ.
- 6.10. Ажилгүй иргэд, залуучуудад хөдөлмөрийн дадлага, мэдлэг, хүмүүжил олгох сургалтын төв байгуулах, ажиллуулах санаачлагыг дэмжинэ.
- 6.11. Ажилгүй иргэд, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын төв, ерөнхий боловсролын сургууль төгсөгчид, тэдний эцэг эхчүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулж хэвшинэ.
- 6.12. Хөдөлмөрийн харилцааг бүх түвшинд, бүх шатанд оновчтой зөв удирдлага, зохион байгуулалтаар хангаж, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хөдөлмөрийн аюулгүй байдлын дэд хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ.

*Хоёрдугаар үе шат: (2021-2025 он): Шинэ технологи, үйлдвэрлэлийн аргад суралцах, бүтээмжийг дээшлүүлэх замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, жижиг дунд бизнесийг дэмжих алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 6.13. Ажиллагчид, албан хаагчдынхаа мэргэшил, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх, нарийн мэргэшлээр сургаж дадлагажуулах, хөгжлийн Бодлогын чиглэлүүдэд шаардлагатай мэргэжлээр чадавхижуулах чиглэлээр үр дүнтэй ажиллаж буй төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг урамшуулж, дэмжинэ.
- 6.14. Үйлдвэр аж ахуйн нэгжүүдэд нарийн мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэн, дадлага хийж байгаа суралцагч нарыг дагалдуулан сургаж, урамшуулал олгодог болно.
- 6.15. Цахим сургалт, зайн сургалтын төв байгуулах замаар иргэдийн мэдлэг боловсрол олж авах үйл ажиллагааг дэмжинэ.
- 6.16. Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс болон Дорнод Их сургуулийг түшиглэн Бизнес инкубаторын төвийг шинээр байгуулна.
- 6.17. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аймгийн дэд санг эргэлтийн сантай болгох, шинээр бизнес санаагаа олсон, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэд болон мэргэжлийн боловсролын байгууллагын төгсөгчдөд гарааны зээл олгоно.
- 6.18. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгох, хөрш зэргэлдээ улс, бусад аймгуудад үйл ажиллагаа явуулахад нь бодлогоор дэмжлэг үзүүлнэ.



- 6.19. Уул уурхай, газрын тосны салбарт шаардлагатай чиглэлээр туршлага, ур чадвар бүхий мэргэжилтэн, боловсон хүчнийг тодорхой хугацаанд урьж ажиллуулах, монгол ажилтнуудыг дагалдуулан сургах улмаар гадаадын ажиллах хүчийг жил дараалан бууруулах асуудлыг гэрээ, хэлэлцээрт тусган хэрэгжүүлнэ.
- 6.20. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлж, баталгаажуулахад чиглүүлнэ.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 3. АЙМГИЙН ЗАСАГЛАЛЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЖ, ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛНА.**

Зорилт 7. Орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлж, төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулна.

*Бүх үе шатанд (2016-2025 он):*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 7.1. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын боловсон хүчний чадавхийг сайжруулах үүднээс мэдлэг чадвар, туршлагатай ахмад мэргэжилтэн, зөвлөхүүдийн холбоог байгуулж, дунд болон залуу үедээ зөвлөгөө, туршлагаасаа хуваалцах бололцоог бүрдүүлнэ.
- 7.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг вэбсайт, телевиз, сонин, сэтгүүл зэрэг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод байдлаар иргэдэд шуурхай хүргэж, төрийн үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 7.3. Шинээр боловсруулагдах Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрт аймгийн хөгжлийн бодлогын тэргүүлэх зорилт, арга хэмжээнүүдийг тусгаж, бүсийн хөгжилд манлайлагч болоход санаачилгатай ажиллана.
- 7.4. Газрын тос боловсруулах үйлдвэр, өнгөт төмөрлөгийн үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, дулааны цахилгаан станц, мах боловсруулах үйлдвэр, арьс шир, ноос боловсруулах үйлдвэр, сүүний үйлдвэр зэрэг улсын болон бүс нутгийн хэмжээний томоохон үйлдвэрийг аймагтаа байгуулахад холбогдох яамд, УИХ-ын гишүүд, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай идэвхи санаачилгатай хамтран ажиллана.
- 7.5. Аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хамтран ажиллах хөтөлбөр боловсруулж, хамтын ажиллагааны уялдаа, үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон гэрээг байгуулж, биелэлтийг жил бүр олон нийтэд тайлагнана.
- 7.6. Алслагдсан суманд ажиллаж буй төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдэх, хил, хязгаарын бүсийн нэмэгдэл олгох замаар тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.
- 7.7. Төрийн байгууллагуудын зарим үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар судалж, орон нутгийн хөгжилд төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.
- 7.8. Орон нутгийн хөгжилд төрийн төв байгууллагуудын шууд харьяа газрууд болон томоохон аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар идэвхи санаачилгатай хамтын ажиллагааг өрнүүлнэ.

Зорилт 8. Орон нутгийн хөгжилд өгөөжтэй, хариуцлагатай, ил тод уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

*Бүх үе шатанд (2016-2025 он):*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 8.1. Уул уурхайн болон бусад аж ахуйн нэгжүүдийн оршин суугаа хаягийн бүртгэлийг тухайн орон нутагт хийлгүүлснээр цалин, хөлсний албан татварын орлогыг орон нутагт төвлөрүүлнэ.
- 8.2. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтэд зарцуулах барьцаа хөрөнгийг нь бүрэн гүйцэд төвлөрүүлж, нөхөн сэргээлт хийж буй байдалд тавих хяналтыг сайжруулна.
- 8.3. Уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит болон хөндлөнгийн хяналтыг оруулах байдлаар үр ашиг багатай, үрэлгэн удирдлагын болон урсгал зардлыг бууруулж, менежментийг сайжруулан цэвэр ашгийг нэмэгдүүлж, улмаар бүтээгдэхүүн хуваах гэрээгээр орон нутагт ногдох орлогыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авна.
- 8.4. Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр орон нутагт ногдох орлогыг бүрэн авч, аймгийн хөгжлийн тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээнд зарцуулна.
- 8.5. Байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрх ашиг, орон нутгийн тогтвортой хөгжил, уул уурхайн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалт ба хариуцлагын хамтран ажиллах гэрээг олборлох үйлдвэрлэл эрхлэгч бүх аж ахуйн нэгжүүдтэй байгуулж ажиллана.
- 8.6. Шингэн ашигт малтмалын тухай хуулийг боловсруулж, батлуулахад санаачилгатай ажиллаж, аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн болон яам, агентлаг зэрэг бусад холбогдох талуудтай хамтран ажиллана.
- 8.7. Уул уурхайн орд, илрэлүүд тэдгээрийн байршил, нөөц, уул уурхайн үйлдвэрлэлийн хайгуул, олборлолт, боловсруулах үйлдвэрлэлийн талаар нэгдсэн цахим мэдээллийн санг байгуулна.
- 8.8. Дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хариуцлагатай уул уурхай эрхлэх, эрх зүйн орчныг сайжруулах, мэдээлэл солилцох, уул уурхайн компаниуд болон орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах үүднээс тодорхой давтамжтайгаар Зүүн бүсийн Уул уурхайн чуулганыг Чойбалсан хотод зохион байгуулна.

## ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ 2: ОЛОН ТУЛГУУРТ, ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГТАЙ, ТЭРГҮҮЛЭХ ХӨГЖИЛТЭЙ АЙМАГ БОЛНО.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 4 (ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ). ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЯЛАГ НӨӨЦӨД ТУЛГУУРЛАН ЭКО-ОРГАНИК, ТЕХНОЛОГИ ШИНГЭЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.**

Зорилт 9. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүс нутгийн онцлог, уламжлалт чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж, мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах, мал аж ахуйг төрөлжүүлэх, тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх алхам.*

### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 9.1. Мал аж ахуйн салбарт мэргэжилтэй ажиллах хүчнийг эрчимжсэн мал аж ахуй, мал эмнэлэг, малын үржлийн чиглэлээр мэргэшүүлэн бэлтгэх, чадавхижуулах, орон нутагт тогтвортой ажиллах бололцоог дэмжинэ.
- 9.2. Мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, халдваргүйжүүлэх, вакцинжуулах ажлыг эрчимжүүлнэ.
- 9.3. Бүс нутгийн онцлог, уламжлалт чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн мал, тэжээвэр амьтдыг төрөлжүүлэн өсгөх стратегийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 9.4. Мал сүргийг орчин үеийн технологийн ололтод тулгуурлан бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл ахуйг тодорхойлох, бүртгэх, мэдээлэх, хянах тогтолцоог бүрдүүлнэ.
- 9.5. Зохиомол хээлтүүлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж өндөр ашиг шимт цэвэр, эрлийз, үүлдэр омгийг үржүүлж, сүргийн эзлэх хувийн жинг нийт малын 25 хувьд хүргэнэ.
- 9.6. Бэлчээрийн төлөв байдал, доройтлын үнэлгээг олон улсын аргачлалаар хийж, менежментийн төлөвлөгөө боловсруулан бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 9.7. Нийт бэлчээрийн 20-аас доошгүй хувийг сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авч цаг хүндэрсэн үед ашиглана.
- 9.8. Шинээр худаг гаргах, засварлах замаар уст цэгийн тоог нэмэгдүүлж, малчид, малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоонд хариуцуулах замаар бэлчээрийн усан хангамжийг 50 хувьд хүргэнэ.
- 9.9. Хадлангийн талбайг зөв зохистой ашиглаж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар хадлан бэлтгэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улсын хэрэгцээнд нийлүүлнэ.
- 9.10. Орон нутгийн түүхий эдэд тулгуурлан бүрэн найрлагат эрдэс тэжээл болон хүчит тэжээл үйлдвэрлэх бага оврын цех байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

- 9.11. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг аймгийн төсвийн 4-өөс доошгүй хувь, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн 20 хувьд хүргэх бодлого баримтална.
- 9.12. Хоршоо, фермерүүдийн үйл ажиллагааг дэмжиж, түүхий эд бэлтгэн нийлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах оновчтой сүлжээг бий болгоход хөдөө аж ахуйн бирж, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.
- 9.13. Мах хадгалах сум дундын зоорь байгуулахад хөнгөлөлттэй зээл, бодлогоор дэмжинэ.
- 9.14. Сумдын мал нядалгааны цехүүдийг сэргээн засварлаж, улсын стандартад нийцсэн сум дундын мал нядалгааны цехтэй болгоно.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 9.15. Сум дундын отрын бүс нутгийн хамгаалалтыг сайжруулах, шаардлагатай талбайг хамгаалалтад авна.
- 9.16. Өндөр ашиг шимт цэвэр, эрлийз үүлдрийн мал сүргийн эзлэх хувийн жинг 35 хувьд хүргэнэ.
- 9.17. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг олон улсын жишигт хүргэнэ.
- 9.18. Бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлж, усан сан, нуур, хөв цөөрөм байгуулж, бэлчээрийн ус хангамжийн түвшинг нийт нутгийн 70 хувьд хүргэнэ.
- 9.19. Багсармал, холимог, хорголжин болон эрдсийн тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, аймгийн эрчимжсэн, хагас эрчимжсэн фермерийн аж ахуйг бүрэн хангаж, экспортолно.
- 9.20. Сум бүрт мах бэлтгэлийн цех байгуулж, борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгоно.
- 9.21. Олон улсын стандартад нийцсэн мал эмнэлгийг Чойбалсан хотод хувийн хэвшлийн хөрөнгөөр байгуулж, мал эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 9.22. Мал, амьтны үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгон генийн санг хамгаалах мал үржлийн биологийн лабораторийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 10. Газрын баялаг нөөцөд тулгуурлан, хөрсний үржил шимд сөргөөр нөлөөлөхгүй, нэгж талбайгаас хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх дэвшилтэт технологид тулгуурлан импортыг орлож, экспортод чиглэсэн газар тариаланг хөгжүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 10.1. Сумдын тариаланд тохиромжтой атар болон атаршсан талбайг эргэлтэд оруулах замаар үр тариа, тэжээлийн ургамлын тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 10.2. Хөрсийг салхины элэгдлээс хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор таримлын сэлгээ, бордоог зөв зохистой хэрэглэж, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.
- 10.3. Услалтын системийн ашиглалтыг сайжруулах, цас, борооны усыг хуримтлуулан хөв цөөрөм байгуулах, ус, эрчим хүчний хэмнэлттэй дуслын болон хөрсөн дороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэн ажиллаж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлагыг дэмжиж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 2200 га-д хүргэж, ургацыг нэмэгдүүлнэ.
- 10.4. Тариалангийн талбайн үржил шимт байдлыг хамгаалах, зохистой ашиглах зорилгоор тухайн жилд тариалах талбайн 50%-аас доошгүй талбайд улаан буудай, 25%-иас илүүгүй талбайд дотоод, гадаад зах зээлд эрэлттэй тосны ургамал тариалах зарчмыг баримтална.
- 10.5. Алслагдсан бүсэд тариалан эрхлэлтийг дэмжих, урамшуулал олгох механизмыг бий болгож, дотоодын хэрэглээнээс илүү гарсан үр тариа, тэжээлийн ургамлын үрийг хилийн боомтоор экспортлох саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 10.6. Төмс, хүнсний ногоо, таримал ургамлын сортыг судлан, нутагшуулах, үр үржүүлэх ажлыг орон нутгийн судалгааны байгууллагад түшиглэн хэрэгжүүлнэ.
- 10.7. Тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор газар тариалангийн сургалт, мэдээллийн төвийг орон нутгийн их, дээд сургуульд түшиглэн байгуулна.
- 10.8. Таримал ургамал, үр үржүүлгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 10.9. Дулааны найдвартай эх үүсвэртэй сумдад жилийн турш үйлдвэрлэл явуулах хүлэмжийн тариалалтыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 10.10. Дорнод дулааны цахилгаан станцаас гарч байгаа илүүдэл уурыг хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлттэй нөхцөлөөр нийлүүлж, дотоодын хүлэмжийн ногооны тариалалтыг нэмэгдүүлэх бололцоог судалж, шийдвэрлэнэ.
- 10.11. Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногооны бага, дунд оврын зоорь, агуулах барих, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 10.12. Чанарын шаардлага хангасан, найдвартай үрийн нөөцийг нэмэгдүүлэх, туршигдсан сайн сортын үрээр үрийн шинэчлэлийг хийх замаар ургацын хэмжээг нэмэгдүүлж хүн амын төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 50 хувь хангана.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж үр ашигтай ашиглах, экспортын баримжаатай тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан тогтвортой хөгжүүлэх алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 10.13. Бүсүүдэд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослон хөгжүүлж, харилцан бие биеэ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор бий болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, загвар аж ахуйн тоог нэмэгдүүлнэ.
- 10.14. Усалгаатай тариалангийн хэмжээг 3000 га-д хүргэж, нэгж га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.

- 10.15. Тариалангийн газрыг байгальд ээлтэй, хөрсний үржил шимийг доройтуулахгүй дэвшилтэт технологийн дагуу үр ашигтай ашиглан, үр тарианы үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, экспортын баримжаатай хөгжүүлнэ.
- 10.16. Аймгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, Зүүн бүсийн нарийн ногооны зах зээлд нийлүүлнэ.
- 10.17. Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, га-гаас авах ургацыг нэмэгдүүлнэ.
- 10.18. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ нөөцлөх, даршлах, савлах үйлдвэр, цехийг байгуулсан иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тогтворжуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 10.19. Хэрлэн суманд “Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв”-ийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

Зорилт 11. Хүнсний болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг гүн боловсруулах хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Мал аж ахуйн түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулах дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлж, мах, сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 11.1. Хэрэглээний гол нэрийн барааны дотоодын үйлдвэрлэл, импортын судалгааг Дорнод аймгийн хэмжээнд жил бүр хийж, мэдээллийн сан бүрдүүлэн үйлдвэрлэл эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад түгээнэ.
- 11.2. Мал нядалгааны газар, боловсруулах үйлдвэрүүдэд олон улсад мөрдөгддөг аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР)-ны стандартыг нэвтрүүлж, эрүүл бүс байгуулах, бүтээгдэхүүнээ экспортлоход тавигдах шаардлагыг бүрэн хангаж, бүтээгдэхүүнээ экспортлох, БНХАУ, ОХУ-ын мах, махан бүтээгдэхүүний импортлогч байгууллагын төлөөлөгчийг Чойбалсан хотод ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 11.3. Гадаадын хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар Чойбалсан хотод мах боловсруулах үйлдвэр байгуулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, хиам, нөөшилсөн махны аймгийн хэрэгцээг бүрэн хангаж, бүтээгдэхүүнээ экспортолно.
- 11.4. Чойбалсан хот орчмын эрчимжсэн фермерийн аж ахуйгаас сүү авч, сүү, тараг, цөцгий, зөөхий, нэрмэл архи, ингэний болон гүүний айраг, ааруул, бяслаг, зайрмаг зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- 11.5. Бүсийн төв сумдад махны зоорь, хөргөлтийн систем бүхий мах боловсруулах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрийг байгуулна.
- 11.6. Дорнод аймгийн дотоодын үйлдвэрүүдийн эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг тус аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа дотоод гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компани, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн үйлчилгээний байгууллагуудад нийлүүлэхийг дэмжинэ.
- 11.7. Дорнод аймгийн бренд бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах чанарыг сайжруулахад анхаарч, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

- 11.8. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, гутал, хувцас, эсгий эдлэлийн жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээлийн болон санхүүгийн бусад дэмжлэг үзүүлнэ.
- 11.9. Зах зээлийг тэлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилгыг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэгчид, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.
- 11.10. Дотоодын нөөцөд түшиглэсэн эрүүл мэнд, гоо сайхны болон бусад “эко” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх биотехнологи, био химийн үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Өндөр технологийн, бүтээмж сайтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 11.11. Гадаадын хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар Чойбалсан хотод мах махан, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүү, сүүн бүтээгдэхүүний аймгийн хэрэгцээг бүрэн хангаж, бүтээгдэхүүнээ экспортолно.
- 11.12. Малын ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийг байгуулах, гутал, савхин болон нэхий хувцас, эсгий эдлэлийн жижиг үйлдвэрүүдийг байгуулахад хөнгөлөлттэй зээлийн болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.
- 11.13. Жижиг оврын хөдөө аж ахуйн техник засварлах, үйлдвэрлэх үйлдвэрийг Чойбалсан хотод байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 11.14. Дотоодын нөөцөд түшиглэсэн эрүүл мэнд, гоо сайхны болон бусад “эко” бүтээгдэхүүнийг экспортлоход дэмжлэг үзүүлнэ.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 5 (ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ). УУЛ УУРХАЙН БОЛОВСРУУЛАХ БОЛОН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ КЛАСТЕРИЙН ХАНДЛАГААР ХӨГЖҮҮЛЖ, БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ДОТООД, ГАДААДЫН ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛНЭ.**

Зорилт 12. Газрын тос, нүүрс, өнгөт төмөрлөг болон барилгын материалын боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлснээр аймгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Уул уурхай, боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татах алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 12.1. Газрын тосны олборлолтоос гарч байгаа илүүдэл байгалийн хийг ашиглан бага оврын хийн үйлдвэр байгуулах талаар судалгаа хийж, холбогдох яамд болон хөрөнгө оруулагч талтай идэвхтэй хамтран ажиллана.
- 12.2. Дорнод аймгийн Улаан, Цав, Мухар, Номинт, Авдар толгой, Алтан Цагаан-Овоо, Салхитын полиметаллын ордуудыг Сүхбаатар аймгийн Төмөртийн Овоо, Хол худаг, Хэнтий аймгийн Мөнгөн-Өндөр, Тугалгатайн нуруун дахь ордуудтай хамтатган

- кластерийн хандлагаар хөгжүүлж, Чойбалсан хот орчимд өнгөт төмөрлөгийн боловсруулах үйлдвэр байгуулах техник-эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж, холбогдох зөвшөөрлийг Засгийн газраас авч, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах ажлуудыг үе шаттайгаар төлөвлөн гүйцэтгэнэ.
- 12.3. Цайр, хар тугалга, зэсийн баяжмал боловсруулах өнгөт төмөрлөгийн үйлдвэрийг Эрдэнэт үйлдвэрийн жишгээр худалдан авагч тал болон хөрөнгө оруулагч гадаад орнуудтай хамтарсан үйлдвэр байгуулах талаар судалж, холбогдох талуудтай хамтарч ажиллана.
  - 12.4. Адуунчулууны хүрэн нүүрсний бүлэг ордыг түшиглэн илчлэг сайтай брикет түлш үйлдвэрлэх, нүүрсийг боловсруулж, шингэрүүлсэн түлш гарган авахад дотоодын аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтыг татаж, тэдгээртэй хамтран ажиллана.
  - 12.5. Адуунчулууны хүрэн нүүрсний бүлэг ордыг түшиглэн малын хүчиллэг тэжээл, газар тариалангийн бордоо болох гумины бордооны үйлдвэр байгуулна.
  - 12.6. Цагаанчулуут, Дөч гол, Тогоотын хөндий зэрэг алтны шороон ордуудын үндсэн ордын хайгуул хийж, нөөцийг нь шинэчлэн тогтоож, цаашид далд уурхайн хэлбэрээр урт хугацаанд ашиглаж, орон нутгийн хөгжилд оруулах өгөөжийг нь нэмэгдүүлэхэд анхаарна.
  - 12.7. Адуунчулууны нүүрсны бүлэг ордын уурхайн хөрс хуулалтын шаврыг ашиглан ердийн болон өнгөлгөөний тоосго, барилгын материалын үйлдвэр байгуулах талаар судалж, энэ чиглэлээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
  - 12.8. Бүс бүрт хоёроос доошгүй аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох тусгай зөвшөөрлийг олгох замаар барилгын материал үйлдвэрлэлд чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, хямд үнэтэй, чанартай барилгын материалыг орон нутагт үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
  - 12.9. Барилгын материалын чанар, стандартыг шалгах лабораторийн барилгыг барьж, дотоодын барилгын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанарыг Монгол Улсын стандартад хүргэнэ.
  - 12.10. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг түшиглэн Чойбалсан хот орчимд цемент, бетон, дүүргэгч барилгын блок, шохой, тоосгоны үйлдвэрлэл бүхий барилгын материалын үйлдвэрийн цогцолборыг байгуулахыг бодлогоор дэмжинэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): уул уурхайн боловсруулах хүнд аж үйлдвэрийн цогцолборуудыг байгуулж, бүтээгдэхүүнээ зүүн хойд азийн зах зээлд нийлүүлэх алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 12.11. Хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан өнгөт төмөрлөгийн “Чойбалсан” боловсруулах аж үйлдвэрийн цогцолборыг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар барина.
- 12.12. Стратегийн ач холбогдол бүхий нүүрс, өнгөт төмөрлөгийн хүдэр, газрын тос, барилгын материалын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль болон татвараас чөлөөлүүлэх, хөнгөлөлт үзүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авна.
- 12.13. Өнгөт төмөрлөгийн үйлдвэрт боловсруулан гарган авсан зэс, молибден, мөнгө, цайр, хар тугалга, кадмий зэрэг өнгөт металлын баяжмал, хайлшан бүтээгдэхүүнийг экспортолж эхэлнэ.



**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 6. ГАЗАРЗҮЙН БАЙРШЛЫН ДАВУУ ТАЛДАА ТУЛГУУРЛАН ЭРЧИМ ХҮЧ, ТЭЭВЭР, ЛОЖИСТИКИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, МОНГОЛ УЛСЫН ТӨВИЙН БҮС БОЛОН ХӨРШ ОРНУУДЫГ ХОЛБОСОН ДЭД БҮТЦИЙН ЗАНГИЛАА ТӨВ БОЛНО.**

Зорилт 13. Байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй технологид суурилсан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аймгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж, илүүдэл эрчим хүчээ экспортолно.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Эрчим хүчний нийлүүлэлтээс давсан хэрэглээг тогтвортой хангахад чиглэсэн арга хэмжээ, зохицуулалтыг хэрэгжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 13.1. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын дэмжлэгээр Дорнод аймагт 100 МВт-ын цахилгаан станцыг шинээр барьж, эсвэл одоогийн “ДБЭХС” ТӨХК-ийн ДЦС-ын хүчин чадлыг 100 МВт болгон өргөтгөж дотоодын эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 13.2. “Багануур – Чойбалсан”-ын 220 кВ-ын өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, төвийн эрчим хүчний эх үүсвэрт холбогдон цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангана.
- 13.3. Чойбалсан сумын нутаг дахь Цавын уурхайгаас Хавиргын боомт хүртэл 15кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барьж,Хавирга хилийн боомтыг дотоодын эрчим хүчээр хангана.
- 13.4. Цахилгаан дамжуулах шугамын алдагдлыг бууруулж, үр ашигтай, хэмнэлттэй, найдвартай ажиллагаа бүхий технологийг нэвтрүүлэх замаар нэгж цахилгаан үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлнэ.
- 13.5. Адуунчулууны нүүрсний бүлэг ордод түшиглэн 300 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, нүүрс, химийн үйлдвэр бүхий цогцолборыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.
- 13.6. Сумын төв болон Чойбалсан хотын захын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 13.7. Суурилагдсан хүчин чадлаас давсан сумдын төвийн толгой дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 13.8. Чойбалсан хотын агаарын бохирдлыг бууруулах, цахилгаан эрчим хүчний хэрэглээний ачааллыг зохицуулах үүднээс гэр хорооллын айл өрхүүдийг хямд үнэтэй шөнийн тариф ашиглах боломжийг бүрдүүлж цагийн ялгаварт тоолуураар хангана.
- 13.9. Хөдөөгийн малчин айл өрхийг нар, салхины сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр 100 хувь хангах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 13.10. Төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрээс алслагдсан багийн төв, эрчимжсэн аж ахуйг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангана.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Эрчим хүч үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аж үйлдвэрийн салбарын хэрэгцээг бүрэн хангах алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 13.11. Өндөр хүчдэлийн шугамын дагуух томоохон суурин газар, жуулчны бааз, багийн төвийг төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбоно.
- 13.12. Зүүн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцуудын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг шинэчлэхэд бодлогоор дэмжинэ.
- 13.13. Сэргээгдэх эрчим хүчний арвин их нөөц, газар зүйн байршлын давуу талаа ашиглан нар, салхин станц байгуулж, төвлөрсөн цахилгаан дамжуулах шугам сүлжээнд холбосноор үйлдвэрлэсэн цахилгаанаа зах зээлд нийлүүлнэ.
- 13.14. Сумдын төвүүдэд нэгдсэн халаалтын уурын зуух, төвлөрсөн инженерийн шугам сүлжээ барина.

Зорилт 14. Орчин үеийн ложистик, зам тээврийн дэд бүтцийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засагт интеграцлагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Улсын зам тээврийн төв тэнхлэг дагуу төмөр зам болон хатуу хучилттай авто замыг байгуулж, гадаад зах зээлтэй шууд холбогдох нөхцөлийг бүрдүүлэх алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 14.1. Зам, эрчим хүчний байгууламж, орон сууц, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын тендерт орон нутгийн 2-4 компанийг консорциум байдлаар нэгтгэн үндсэн болон туслан гүйцэтгэгчээр оролцуулж, боловсон хүчин, хөрөнгө санхүү, тоног төхөөрөмж, материаллаг баазаа нэгтгэн өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 14.2. Газрын тосны 21-р талбайгаас 19-р талбай-Баянхошуу боомт хүрсэн хатуу хучилттай авто зам хүртэл 68 км шороон замаар хүнд даацын автомашинууд олон салаа зам гарган Мэнэнгийн талын экосистемийг ихээр доройтуулж буй тул энэ чиглэлд хатуу хучилттай зам барихад газрын тосны олборлолтын компанитай хамтран ажиллана.
- 14.3. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн үргэлжлэл болгон Чойбалсан хотоос Тосон-Уулын газрын тосны 21-р талбай хүртэл 220 км хатуу хучилттай авто зам байгуулж, аймгийн төвийг Халхгол сумын Ялалт баг болон Баянхошуу хилийн боомт хүртэл хатуу хучилттай автозамаар холбоно.
- 14.4. Аймгийн төвтэй хамгийн ойр байрлах Чойбалсан хотоос Хавирга хилийн боомт хүртэл 124 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 14.5. Аймгийн зам арчилгаа, засварын чадамжийг нэмэгдүүлэх үүднээс аймагт нэвтрэх авто тээврийн хэрэгслээс хураамж авах постуудыг байгуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн авто зам арчилгаанд зарцуулна.
- 14.6. Чойбалсан хотын авто замын сүлжээг өргөжүүлж, уулзваруудын нэвтрэн өнгөрүүлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор “Гудамж” төслийг хэрэгжүүлнэ.
- 14.7. Автозам, замын байгууламжийн шинэчлэл, засвар, арчлалт, тэмдэгжүүлэлтэд стандартын шаардлага хангуулна.
- 14.8. Жил бүр 200 мянгаас доошгүй төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн санд тусган төлөвлөж, автозамын дагуу тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллэх самбар байрлуулах арга хэмжээг зохион байгуулна.
- 14.9. Баянхошуу, Хавирга, Эрээнцавын хилийн боомтуудын хүчин чадлыг өргөтгөж, ачаа болон зорчигч тээврийн нэвтрэн өнгөрөх чадавхийг сайжруулна.

- 14.10. Хүнд даацын ачааны машинуудаас болж, авто зам эвдэрч байгаад дүгнэлт хийж, баригдаж буй замын чанар болон зам ашиглалтад орон нутгийн зүгээс хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарна.
- 14.11. Шинээр авто зам барих болон эвдэрсэн замыг засахад шаардлагатай материалыг орон нутгаас хангах асфальт бетоны үйлдвэрийг Дорнод аймагт байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 14.12. Авто замын засвар, арчлалтын орон нутгийн өмчит компанийг байгуулж, зам барилгын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 14.13. Чойбалсан хотын 6.8 км урт хойд төв замыг шинэчлэн өргөтгөн төв замын нэвтрэн өнгөрөх чадавхийг сайжруулна.
- 14.14. Чойбалсан хотын Хэрлэн голын дунд модон гүүрийг цемент бетон гүүр болгон шинэчлэн барьж, хот Хэрлэн голоос урагш тэлэн хөгжих бололцоог хангана.
- 14.15. Автозам, замын байгууламжийн шинэчлэл, засвар, арчлалт, ашиглалтын байдалд тавих орон нутгийн байгууллагын хяналтыг чангатгах, түүнд иргэд, олон нийтийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Аймгийн доторх бүсүүд болон хилийн бүх боомтыг хатуу хучилттай замаар Чойбалсан хоттой холбож, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 14.16. Монгол улсын хэмжээнд аймгийн төвөөс хамгийн хол алслагдсан Халхгол суманд агаарын тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх бетонон зурвастай аэродром бүхий нисэх онгоцны буудал барьж, энэ чиглэлд тогтмол нислэг үйлддэг болно.
- 14.17. Чойбалсан-Чита, Чойбалсан-Рашаант агаарын шинэ зам нээн олон улсын чиглэлд агаарын зорчигч тээврийн үйлчилгээг нэвтрүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, улмаар Зүүн хойд Азитай агаарын замаар холбогдоно.
- 14.18. Баруун хойд бүсийн сумдыг аймгийн төвтэй холбосон Чойбалсан хот-Цагаан-Овоо-Баян-Уул-Ульхан чиглэлийн 245 км хатуу хучилттай авто замыг байгуулна.
- 14.19. Халхгол сумын Ялалт багийн төвөөс Халх гол сумын төв/Сүмбэр/ хүртэл 70км хатуу хучилттай авто замыг барина.
- 14.20. Халхгол сумын төвөөс Сүмбэр боомт хүртэл 85км хатуу хучилттай авто замыг барина.
- 14.21. Чойбалсан-Баян-Уул-Ульхан боомт, Чойбалсан-Буйрнуур-Халхгол-Баянхошуу боомт-Халхгол сум, Чойбалсан-Хөхнуур-Эрээнцав боомт, Чойбалсан-Хавирга боомт гэсэн аялал жуулчлалын 4 гол чиглэлд авто замын хүрэх чиглэл, зай болон аялал жуулчлалын гол цэгүүдийг заасан мэдээллийн самбарыг монгол, англи хэл дээр байгуулна.
- 14.22. Хилийн боомтуудын дэд бүтэц, барилга байгууламж, техник хэрэгслийг сайжруулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 14.23. Монгол Улсын төрөөс Төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод тодорхойлсны дагуу Баруун-Урт –Хөөт (140 км), Хөөт –Чойбалсан (150 км) чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ханган нийлүүлэлтийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үүднээс эхний ээлжинд шаардлагатай боловсон хүчнийг орон нутгаас бэлтгэх, мөн төмөр замын суурийн бетон дэр болон бусад материалыг Чойбалсан хотод үйлдвэрлэж, нийлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 15. Орчин үеийн мэдээлэл, харилцаа, холбооны дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл холбооны үйлчилгээг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он):*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 15.1. Аймгийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүхий вэбсайт дата төвийг байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд бүх төрлийн мэдээллийг шуурхай авах бололцоо нөхцөлийг бүрдэнэ.
- 15.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон төрийн үйлчилгээний бүх байгууллагууд нь өөрийн цахим хуудсаар дамжуулан e-office хэлбэрээр үйлчилгээгээ иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад ил тод, нээлттэй, хурдан шуурхай хүргэнэ.
- 15.3. Төрийн байгууллага, албан хаагчид, иргэдэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлнэ.
- 15.4. Дорнод аймгийн холбооны газрын дэргэд 30-40 м өндөр холбооны төв цамхагийг байгуулж, интернет, үүрэн холбоо, телевиз, радионы үйлчилгээний хурд, багтаамжийг нэмэгдүүлнэ.
- 15.5. Чулуунхороот, Халхгол, Дашбалбар сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбосноор бүх сумдын айл өрх, албан байгууллагууд интернетийн үйлчилгээгээр хангагдах боломжтой болно.
- 15.6. Хот, суурин газруудын оршин суух хаягжилтын системүүдийн хоорондын уялдааг сайжруулж, шуудан, илгээмжийн үйлчилгээг шуурхай, хялбар хүргэнэ.
- 15.7. Аймгийн бүх сумдад орон нутгийн телевиз, радиогийн сувгуудын нэвтрүүлгийг дуу, дүрсний өндөр нягтралтайгаар шууд хүлээн авах бололцоог бүрдүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он):*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 15.8. Сумдын төвийн үүрэн холбооны сүлжээний цамхагуудыг өндөрсгөж, сүлжээний тархалтыг сайжруулах талаар санаачилгатай ажиллана.
- 15.9. Чойбалсан хотын шилэн кабелийн шугамыг шинэчилж, айл өрх, аж ахуйн нэгжүүдийг өндөр хурдны интернетийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 15.10. Иргэд олноор зорчдог автозамын дагуу үүрэн телефоны сүлжээг бүрэн нэвтрүүлнэ.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 7. БАЙГАЛИЙН БОЛОН ТҮҮХ, СОЁЛЫН НӨӨЦӨД ТУЛГУУРЛАН ДОТООД, ГАДААД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ДАГАЛДАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР, ДЭД БҮТЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ.**

Зорилт 16. Аялал жуулчлалын салбарын мэдээллийн хүртээмжийг сайжруулж маркетинг, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх замаар жуулчдын тоог өсгөж, Зүүн Хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Аялал жуулчлалын салбарын мэдээллийн хүртээмжийг сайжруулж маркетинг, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 16.1. Дорнод аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөг мэргэжлийн болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр боловсруулна.
- 16.2. Дотоод, гадаадын их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, аялал жуулчлалын компаниудтай хамтран “Дорнод аймгийн аялал жуулчлалын нөөц, боломж” сэдэвт бизнес зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулна.
- 16.3. Дорнод аймгийн аялал жуулчлалын талаарх нэгдсэн вэб сайтын домайн хаягийг сольж, вэб сайтаа монгол, англи, хятад, орос гэсэн 4 хэл дээр хийнэ.
- 16.4. Улаанбаатар хотод жил бүр зохион байгуулагддаг аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнгүүдэд зохион байгуулалттайгаар тогтмол оролцож, олон улсын болон дотоодын аялал жуулчлалын компаниудтай бизнес уулзалт хийх боломжийг дэмжнэ.
- 16.5. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор Улаанбаатар хотын аяллын оператор компаниудыг Дорнод аймагт жил бүр аялуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 16.6. Фото зураг, авто групп, сэтгүүлчдийн, судлаачдын зэрэг сэдэвчилсэн аялалуудыг зохион байгуулахад хамтран ажиллана.
- 16.7. Зүүн бүс, улсын болон олон улсын чанартай хурал, семинар, спортын тэмцээн, соёл урлагийн арга хэмжээг Дорнод аймагт зохион байгуулж, бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэхэд идэвхи санаачилгатай ажиллана.
- 16.8. Аймгийн түүх, соёл, онцлогийг харуулсан чанартай бэлэг дурсгалын зүйлсийг (ил захидал, түлхүүрийн оосор, хөргөгчний наалт, аялал жуулчлалын товхимол, газрын зураг, бусад сувенир) бүтээх уралдаан зарлаж, шалгарсан бүтээлүүдийг үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 16.9. Ирээдүй хойч үедээ дайны хор уршгийг ойлгуулах, ахмад үеийнхээ гавьяа зүтгэлийг алдаршуулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их дээд сургуулиудын оюутнуудад зориулсан “Энх тайвны төлөө Дорнод” аяллын хөтөлбөрийг боловсруулж, аймаг, улсын боловсролын хөтөлбөрт тусгуулна.
- 16.10. Алтаргана, Алтан дөрөө, Баргажин, Эв модны наадам, Цагаан сар угтах ёслол, Цас мөсний баяр зэрэг угсаатны бүлгүүдийн уламжлалт урлаг, соёлын томоохон арга хэмжээг тогтмол давтамжтайгаар салбарын яам, аялал жуулчлалын томоохон тур компаниуд, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулж, цар хүрээ, оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.
- 16.11. Жил бүр Их бурхант цогцолборт Дашням аравнай өргөх ёслолыг зохион байгуулж Итгэлт хамбын жишгээр маркетинг хийж жуулчдыг татна.

- 16.12. Халхын голын түүхэн ялалтын ойг тохиолдуулж, Дорнод аймгийн түүх, соёл болон өнөөгийн хөгжил, аялал жуулчлалын талаар цуврал нэвтрүүлгийг бэлтгэж, улс даяар нэвтрүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 16.13. Монголын Бурхан Шашны төв Гандантэгчинлэн хийдтэй хамтран “Их Бурхантын тахилга” Зүүн бүсийн даншиг наадмыг гурван жил тутамд нэг удаа зохион байгуулна.
- 16.14. Дорнод аймгийн аялал жуулчлалын газрын цахим хуудасны хайлтын илрэцийг нэмэгдүүлэх зорилгоор төлбөртэй домайн байршуулах, олон нийтийн сүлжээний цахим хуудсуудыг нээн ажилуулж, аялал жуулчлалтай холбоотой үйл явдал, мэдээ мэдээллийг зорилтод бүлгүүдэд хүргэнэ.
- 16.15. Их түмэн санаачилгын Зүүн Хойд Азийн бүс дэх “Олон чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” хөтөлбөрт дотоодын аяллын хөтөлбөр, төлөвлөгөөг танилцуулах, санал болгох замаар идэвхитэй байр суурьтай оролцоно.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Гадаад, дотоодын жуулчдыг мэдээ мэдээллээр бүрэн хангаж, үзвэр үйлчилгээний чанарыг дээшлүүлэх замаар Зүүн Хойд Азийн орнуудын жуулчдыг татах алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 16.16. “Жуулчдад үйлчлэх мэдээллийн төв”-үүдийг Чойбалсан хот, хилийн боомтууд, Хөлөнбуйр сум зэрэг аяллын маршрутын дагуух газруудад байгуулж, дотоод, гадаадын жуулчдыг харилцаа холбоо, тээвэр, жуулчны бааз, аяллын маршрут, хөтөлбөр, газрын зураг зэрэг мэдээ, мэдээллээр хангана.
- 16.17. Эрээнцав, Хавирга боомтуудад хөрш орнуудын бизнес аяллыг хөгжүүлэх зорилгоор хил орчмын “аялал жуулчлалын чөлөөт бүс” байгуулах боломжийн талаар судалж, холбогдох талуудтай хамтран ажиллана.
- 16.18. Хөрш орнуудын хил залгаа муж, аймгуудын аялал жуулчлалын газартай хамтран аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг чадавхижуулах нэгдсэн сургалт, дадлага, туршлага солилцох арга хэмжээг давтамжтайгаар зохион байгуулна.
- 16.19. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, төрөлжүүлэх, чанар стандартыг сайжруулах үүднээс олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулж, аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт хийж, сайжруулна.
- 16.20. Хөрш орнуудын хот, мужуудтай “ах дүү хотын гэрээ” байгуулж, өөрийн аялал жуулчлалын хөтөлбөрөө танилцуулах, хамтран туршлага солилцох замаар жуулчдыг татна.
- 16.21. Гадаад, дотоодын нислэгийн тоог жуулчлалын улирлын эрэлттэй үед нэмэгдүүлэх, хот хоорондын тээвэр үйлчилгээний чанар, сонголт, хуваарийг сайжруулах талаар холбогдох газруудад санал тавьж шийдвэрлүүлнэ.
- 16.22. Их түмэн санаачилгын Зүүн Хойд Азийн бүс дэх “Олон чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд хил дамнасан тогтвортой аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулах, хүний нөөц бэлтгэх, брэндинг болон маркетингын сургалт үйл ажиллагаанд орон нутгийн төлөөллийг идэвхтэй хамруулна.

Зорилт 17. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсронгуй болгон бусад салбартай үялдуулан хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, “нутгийн брэнд” бүтээгдэхүүн бий болгон эрэлт, нийлүүлэлтийг дэмжих алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 17.1. “Улаанбаатар-Чойбалсан-Манжуур” чиглэлд аялал зохион байгуулдаг жуулчны операторуудтай хамтран боломжит маршрут, хөтөлбөрийг боловсруулж, Дорнод аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл, урлаг, худалдаа үйлчилгээний төвүүд, үзвэрийн газрууд, зочид буудлын үйл ажиллагааг дэмжинэ.
- 17.2. Аяллын маршрут дагуух түр буудаллах, хоноглох, отоглох цэгүүдийг тэмдэгжүүлж, түр зогсоол, амралтын цэг, сувенир худалдааны төвүүд болон фото зурагтай холбоотой дэд бүтцийг стандартын дагуу байгуулна.
- 17.3. Түүх, соёлын биет болон биет бус үзмэрүүдийг сэргээн засварлаж, сонирхолтой үзвэр үйлчилгээгээр өргөжүүлэн, жуулчинд үйлчлэх цэгүүдийн тоог нэмэгдүүлнэ.
- 17.4. Улсын түвшний томоохон худалдаа үйлчилгээний төв, зочид буудал, зоогийн газрын сүлжээг Дорнод аймагт нэвтрүүлэхийг дэмжинэ.
- 17.5. Жуулчдад үзүүлэх үзмэрийг нэмэгдүүлэх зорилгоор байгалийн зоо парк, морин тойруулга, уралдааны төв, цирк, агаарын спортын төв, загас сонирхогчдын клуб зэрэг байгаль хамгаалалын төдийгүй аялал жуулчлалын үзмэр, цогцолборыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.
- 17.6. Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний дагуу нутгийн иргэдэд түшиглэн “Зогсоол болгоны брэнд” хөтөлбөр хэрэгжүүлэн түүний технологи, үйлдвэрлэл, маркетинг сурталчилгаа, худалдан авалт, дэд бүтцийг сайжруулахад төр, хувийн хэвшил, хөрш орнуудын хамтын ажиллагааны хүрээнд дэмжинэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Олон улсын түвшинд өрсөлдөх брэнд аяллын хөтөлбөр, үйлчилгээ, дэд бүтэцтэй болох алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 17.7. Буйр нуурын байгалийн тогтоцыг түшиглэн эх газрын цэнгэг усны наран шарлагын төвийг элсэн саун, эмчилгээ, бариа засал, элсний спорт, болон бусад үйлчилгээгээр баяжуулан цогцолбор байдлаар байгуулна.
- 17.8. Аялал жуулчлалын голлох зах зээл бүхий хотууд руу агаарын шууд нислэг хийх боломжийг судалж, холбогдох байгууллагуудад хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.
- 17.9. Дотоодын жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор үндэстэн, ястны соёл, зан заншлыг илтгэсэн худалдаа үйлчилгээний гудамжийг Чойбалсан хотод байгуулна.
- 17.10. Чойбалсан хотын соёл, спортын цогцолборыг олон улсын стандартад нийцүүлэн шинээр байгуулж, олон улсын хурал цуглаан, үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн, бизнесийн арга хэмжээг зохион байгуулах, хүлээн авах замаар бизнесийн болон спортын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 8. ОХУ, БНХАУ-ЫН ХИЛ ЗАЛГАА МУЖУУД, ЗҮҮН АЗИЙН ОРНУУДАЙ ХАРИЛЦАН АШИГТАЙ ГАДААД ХУДАЛДАА, ИДЭВХИТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЖ, ЗҮҮН ХОЙД АЗИЙН ИНТЕГРАЦИД НЭГДЭН, ТЭЭВЭР, ЛОЖИСТИК, ХУДАЛДААНЫ ТОМООХОН ТӨВ БОЛНО.**

Зорилт 18. Хил залгаа мужууд, Зүүн Хойд Азийн орнуудтай тогтоосон найрсаг хамтын ажиллагаагаа өргөжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчдийг татах чиглэлд “санаачилгатай” ажиллаж, аймгийн тэргүүлэх салбаруудын хөгжлийг дэмжинэ.

*Бүх үе шат (2016-аас 2025 он):*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 18.1. Чойбалсан хотод хөдөө аж ахуйн түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанарыг шинжлэх олон улсын түвшний лабораторийг байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад олон улсын байгууллагуудын техникийн зөвлөгөө, хүний нөөцийн туслалцаа авна.
- 18.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлох боломжтой орнуудын мал эмнэлгийн болон хорио цээрийн салбарын мэргэжилтнүүдтэй хамтран мал эрүүлжүүлэх, зэрэглэл тогтооход хамтран ажиллах замаар бүтээгдэхүүн нийлүүлэх баталгаа гаргуулна.
- 18.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлох боломжтой орнуудад бүтээгдэхүүн нийлүүлэхэд тавигддаг хорио цээрийн шаардлага, стандартын талаарх мэдээллээр үйлдвэрлэгчдийг хангана.
- 18.4. Дорнод аймагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг хөрш орнуудад борлуулах гарц, сувгийг нээж, дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг тэлнэ.
- 18.5. Хөрөнгө оруулалт шаардлагатай, харилцан үр ашигтай хамтран ажиллах бололцоотой чиглэлүүдийг тодорхойлж, Дорнод аймгийн нөөц, боломж, бодлогын чиглэлүүдийн танилцуулга бүхий чанарын шаардлага хангасан төслүүдийг мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр боловсруулж, бэлтгэнэ.
- 18.6. Өндөр хөгжилтэй орнуудтай биотехнологи, жижиг дунд үйлдвэр, эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажиллах боломжийг судална.
- 18.7. Эрчим хүч, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарт өндөр технологи, ноу хау нэвтрүүлэх чиглэлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.
- 18.8. Гадаадын хөрөнгө оруулагчид, аялагчдыг мэдээ, мэдээллээр хангах, хууль эрх зүйн болон бодлогын товч танилцуулга, нөөц боломжийг харуулсан цахим хуудас нээж, тэдний асуулт, санал хүсэлтийг хүлээн авах онлайн шугамыг нэвтрүүлнэ.
- 18.9. Орон нутгийн онцлогт тохирсон зохистой шийдлийг эрэлхийлэх үүднээс ОХУ, БНХАУ болон бусад орны эрдэмтдийг оролцуулан хөрөнгө оруулалтын орчны хамтарсан судалгаа хийнэ.
- 18.10. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, орон нутгийн их, дээд сургуультай хамтран “Хөрөнгө оруулалт-Хөгжлийн үндэс” сэдвээр холбогдох мэргэжилтнүүд, судлаачид, Монгол болон хөрш орнуудын хил залгаа бүс нутгийн оюутнуудын дунд эрдэм шинжилгээ, судалгаа, бүтээлийн уралдааныг тогтмол зохион байгуулна.
- 18.11. Дорнод аймгийн Халхгол суманд аялал жуулчлал, хөдөө аж ахуйн чиглэлээр эдийн засгийн чөлөөт бүс байгуулах бололцоог судалж, холбогдох байгууллагуудад санал тавьж идэвхтэй хамтран ажиллана.



- 18.12. “Зүүн бүс түншлэл”, “Гурван улсын хил залгаа бүс нутгийн аялал жуулчлалын форум” зэрэг уламжлалт уулзалт, форумуудын хамрах хүрээг өргөжүүлж, хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт зохион байгуулж, шаардлага хангасан, бодитой, төслүүдийг сонирхогч талд танилцуулж, хамтран ажиллана.
- 18.13. Хөрш орнуудын хил залгаа мужуудтай санамж бичгийн хүрээнд хөдөө аж ахуй, эрчим хүч, тээврийн болон соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаагаа эрчимжүүлнэ.
- 18.14. БНХАУ-ын зүүн хойд гурван муж болох Хар Мөрөн, Жилин, Ляонин муж болон бусад хот, мужтай найрсаг харилцаа тогтоож, улс төр, эдийн засаг, худалдаа, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүч зэрэг салбарт хамтран ажиллана.
- 18.15. ОХУ, БНХАУ болон Зүүн Азийн орнуудтай оюутан солилцоо, соёл, хүмүүнлэгийн харилцаагаа өргөжүүлж, аймгийн тэргүүлэх салбаруудын хөгжлийг дэмжинэ.
- 18.16. ОХУ, БНХАУ-ын хил залгаа мужуудын худалдааны төлөөлөгчийн газрыг Чойбалсан хотод нээж, хоёр талын хилийн худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хамтарч ажиллана.
- 18.17. Боомтуудын дэд бүтэц, барилга байгууламж, техник хэрэгслийг сайжруулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд санаачилгатай ажиллана.
- 18.18. Хөрөнгө оруулагчид болон жуулчдын тав тухыг хангах үүднээс ОХУ-ын Чита, БНХАУ-ын Рашаант болон бусад том хотуудын чиглэлд зорчих эрэлт хэрэгцээ, боломжийг судалж, шаардлагатай чиглэлүүдэд олон улсын иргэний агаарын нислэг үйлдэх асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлнэ.
- 18.19. Олон улсын төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 18.20. “Их Түмэн санаачилга”-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Зүүн Хойд Азийн улс орнуудтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн, үр ашигтай хамтран ажиллана.

#### **БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 9. ХӨГЖЛИЙН НӨӨЦ, ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛДАА ТУЛГУУРЛАН СУМДЫГ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГААР ХӨГЖҮҮЛНЭ.**

Зорилт 19. Хөгжлийн нөөц, давуу тал болон нийгэм-эдийн засгийн таталцалд тулгуурлан аймгийн сумдыг бүсчилсэн хөгжлийн зарчмаар Өмнөд, Төвийн, Баруун хойд, Зүүн хойд гэсэн 4 бүсээр хөгжүүлнэ.

*Төвийн бүс нь Хэрлэн (Чойбалсан хот) суманд төвлөрч Баянтүмэн, Булган, Сэргэлэн, Хөлөнбуйр, Чойбалсан сумдыг хамрах бөгөөд аймгийн төдийгүй Зүүн бүсийн боловсруулах аж үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй, худалдаа, үйчилгээний төв болон хөгжинө.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 19.1. Чойбалсан хот орчимд газрын тос боловсруулах үйлдвэр, өнгөт төмөрлөгийн үйлдвэр, нүүрс боловсруулж шингэрүүлсэн хий гарган авах үйлдвэрүүдийг барих хөрөнгө оруулагч талтай хамтран ажиллаж, газар олгох, барилга байгууламж барихад зөвшөөрөл олгох, орон нутгаас мэргэшсэн ажиллах хүчнээр хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 19.2. Чойбалсан хотын ашиглахаа больсон үйлдвэрүүдийн материаллаг баазад тулгуурлан арьс шир боловсруулах, ноос угаах, хивс үйлдвэрлэх, мах боловсруулах зэрэг эмэгтэй

- ажиллагчид түлхүү ажиллах хөнгөн хүнсний салбарын үйлдвэрүүдийг сэргээж, ажиллуулахад хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлнэ.
- 19.3. Чойбалсан хот орчимд болон Баянтүмэн суманд махны чиглэлийн улаан, мах-сүүний чиглэлийн казакийн цагаан толгойт, Баянтүмэн, Сэргэлэн, Булган, Чойбалсан сумдад симментал үүлдрийн үхрийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.
- 19.4. Булган суманд сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэр, Тугийн сүмийг түшиглэн аялал жуулчлалын бааз байгуулна.
- 19.5. Баянтүмэн суманд үхрийн эрчимжсэн фермерийн аж ахуй, төмс, хүнсний ногоо тариалах, гахай, тахианы туслах аж ахуйг болон дүүргэгч блок, улаан тоосго зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ.
- 19.6. Сэргэлэн суманд үзэмчин омгийн хонийг үржүүлэхийн зэрэгцээ сүүний чиглэлийн үхэр үржүүлэн мах, сүүгээр аймгийн төв, суурин газрын хэрэгцээг хангах фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 19.7. Чойбалсан суманд Утаат Минжүүрийн рашааныг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 19.8. Хөлөнбуйр суманд улсын брэнд болсон мах, ноосны гарц сайтай илүү нугаламтай барга хонийг өсгөн үржүүлж, бусад аймаг, сумдад нийлүүлнэ. Мөн Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн автозамын дамжин өнгөрөх 123-ын зогсоолд түшиглэн эрүүл ахуйн стандартад нийцсэн хоолны газар, дэлгүүр бүхий худалдаа, үйлчилгээний цогцолбор байгуулж, аялал жуулчлалын орлогоо нэмэгдүүлнэ.

*Өмнөд бүс нь Халхгол суманд төвлөрч, Матад сумыг хамрах бөгөөд аймгийн үр тариа, хадлан бүхий газар тариалан, аялал жуулчлал, гадаад худалдааны төв болон хөгжинө.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 19.9. Халхгол суманд орон нутгийн нөхцөлд дасан зохицсон элит сортын үр үржүүлгийн аж ахуйг хөгжүүлж, нэгж га-аас хураан авах улаан буудай, үр тарианы ургацыг нэмэгдүүлж, төмс, хүнсний ногооны тариалалтыг хөгжүүлснээр газар тариалангийн салбар нь бүсийн эдийн засгийн тэргүүлэх салбар болно.
- 19.10. Хадлангийн нөөц газраас байгалийн нөхөн сэргээгдэх баялаг болох хадлан, өвс тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлж, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүнээ зүүн бүс болон улсын хэрэгцээнд нийлүүлэхээс гадна хил залгаа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган, Хөлөнбуйр аймгуудад экспортолно.
- 19.11. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлэх үүднээс шош, эрдэнэшиш, наранцэцгийн ургамал, чихрийн манжин, жимс жимсгэнэ зэрэг ургамлын тариалалтыг эрхлэх талаар судалгаа хийж, тэдгээрт хөрөнгө оруулагчдыг татах, дэд бүтцийн нөхцөлийг нь сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 19.12. Зөгийн аж ахуй эрхлэлтийг дэмжиж, цэвэр зөгийн балаар дотоодын хэрэгцээг хангаж, экспортолно.
- 19.13. Сум дундын эмнэлэг болон 12 жилийн бүрэн дунд сургууль, Ялалт багийн дунд сургуулийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дэмжин, материаллаг баазыг нь нэмэгдүүлж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 19.14. Буйр нуурын загас агнуурын нөөцөд түшиглэн загасны мах нөөшлөх, загас үржүүлэх үйлдвэрийг байгуулж, бүтээгдэхүүнээ БНХАУ болон дотоодын зах зээлд нийлүүлнэ.

- 19.15. Халхын гол, Буйр нуур, Мэнэнгийн тал, Хянганы ойн нөөц зэрэг байгалийн, Их бурхантын цогцолбор, Халхголын дайчдад зориулсан хөшөө дурсгалууд, Ялалтын музей түүх, соёлын нөөцөд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлж, орчин үеийн жишигт нийцсэн дэд бүтцийг бий болгож, амралт, сувиллын газар, аялал жуулчлалын бааз байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.
- 19.16. Халхголын мухар хэвшлийн үхэр сүргийг өсгөж, үхрийн органик мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 19.17. Матад суманд хурдан удмын адуу, давхар зогдорт тэмээг өсгөн үржүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.
- 19.18. Газрын тосны олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын хүнсний хэрэгцээнд мах болон сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс үхрийн эрчимжсэн аж ахуй болон гахай, шувууны туслах аж ахуйг хөгжүүлнэ.
- 19.19. Орон нутгийн иргэдийг мэргэшүүлэн тогтвортой ажлын байраар хангах болон сумын хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар газрын тос олборлогч компаниудтай хамтран ажиллана.
- 19.20. Чойбалсан-Халхгол чиглэлийн автозам дагууд эрүүл ахуйн стандарт шаардлагад нийцсэн хоолны газар, дэлгүүр зэрэг үйлчилгээний байгууллагуудыг байгуулна.
- 19.21. Баруун-Урт-Чойбалсан чиглэлийн төмөр зам баригдсанаар Хөөтийн нүүрсний уурхай ашиглах бололцоо бүрдэж, шахмал түлшний үйлдвэр байгуулах талаар судалгаа хийж, орон нутгийн иргэдийг ажлын байрыг нэмэгдүүлнэ.

*Баруун хойд бүс нь Баян-Уул суманд төвлөрч, Баяндун, Цагаан-Овоо сумдыг хамрах бөгөөд мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, модны болон мод үржүүлгийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн төв болон хөгжинө.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 19.22. Баян-Уул суманд бүсийн хэмжээний мах хадгалах зоорь, мах бэлтгэн нийлүүлэх төв болон мах боловсруулах үйлдвэр байгуулж, бүтээгдэхүүнээ Ульхан боомтоор ОХУ-д нийлүүлнэ.
- 19.23. Баян-Уул суманд Онон Балжийн байгалийн нөөц газрыг түшиглэн аялал жуулчлалын бааз, Эрээний модны үйлдвэрийн суурин дээр гэр ахуйн мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл байгуулах, жимс, жимсгэнэ тариалах, нөөцлөх, савлах аж ахуйг хөгжүүлнэ.
- 19.24. Баяндун суманд Наран булаг, Могойтын рашааныг түшиглэн рашаан, цэвэр усны үйлдвэр, хүнсний ногоо тариалах, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх, сүү, цагаан идээний үйлдвэр байгуулна.
- 19.25. Цагаан-Овоо суманд үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, үйлдвэрийн аргаар хорголжин, багсармал тэжээл бэлтгэх, төл, малын арьс элдэх, анхан шатны боловсруулалт хийнэ.
- 19.26. Ойн нөөцөө хамгаалах үүднээс түлээний модоо Баян-Уул, Баяндун сумдаас, харин цонх хаалга, байшин зэрэг үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээний модоо Ульхан боомтоор ОХУ-аас хямд үнэтэй худалдан авна.

*Зүүн хойд бүс нь Дашбалбар суманд төвлөрч, Чулуунхороот, Гурванзагал сумдыг хамрах бөгөөд уул уурхай, гадаад худалдаа, тээвэр, болон махны чиглэлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн төв болон хөгжинө.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 19.27. Чулуунхороот суманд мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулж, бүтээгдэхүүнээ Эрээнцавын боомтоор ОХУ-ын зах зээлд нийлүүлнэ.
- 19.28. Дашбалбар сумын Чух нуурын амралт, сувиллын газар, Чойбалсан сумын Хөх нуурыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлж, Цагаан хөндийн рашааныг савлах, махны жижиг үйлдвэр, малын түүхий эд боловсруулах цех ажиллуулна. Дашбалбар суманд буриад хонь, Чулуунхороот, Чойбалсан сумдад сүү болон махны чиглэлийн үхрийг түлхүү өсгөнө.
- 19.29. Чулуунхороот суманд хүлэмжийн аж ахуйгаар нарийн ногоо тариалан боловсруулалт хийж савлах, талх, нарийн боовны цех болон гахай, тахианы аж ахуй хөгжүүлнэ.
- 19.30. Гурванзагал суманд байгалийн хадлан бэлтгэх, Манлай ван Дамдинсүрэнгийн хөшөө музейг өргөтгөн ахмад үеийн дайчин уламжлалыг сурталчлах төв байгуулна.
- 19.31. Хил залгаа 3 улсын нутаг дэвсгэрийг хамарсан Дагуурын олон улсын дархан цаазат газрын сүлжээг байгуулж, дэлхийн байгалийн өвд бүртгүүлэхэд холбогдох судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 19.32. Орон нутагт хариуцлагатай уул уурхай эрхлэхэд хяналт тавьж, Дашбалбар сум дахь Улааны болон Мухарын цайр, хар тугалганы ордыг түшиглэсэн уулын баяжуулах үйлдвэрлэлд орон нутгийн иргэдийг мэргэшүүлэн сургаж ажиллуулах, бүсийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд уул уурхайн компаниудтай хамтран ажиллана.

### **ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ 3: ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.**

**БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 10. БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН НӨӨЦИЙГ ТҮҮНИЙ НӨХӨН СЭРГЭХ ЧАДАВХИД НЬ ТОХИРУУЛАН АШИГЛАЖ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ЗАМААР БАЙГАЛИЙН УНАГАН ТӨРХИЙГ ХАДГАЛНА.**

Зорилт 20. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулахад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг багасгана.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Орчны бохирдлыг багасган, хяналт шинжилгээг сайжруулан, эвдрэлд орсон газруудад нөхөн сэргээлт хийх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 20.1. Ил задгай хог хаях, усан сан бүхий газрыг бохирдуулах зэрэг иргэд, аж ахуй нэгж байгууллагын хариуцлагагүй байдлыг бууруулахад чиглэсэн ухуулга сурталчилгааг тогтмол хийж, тавих хяналтыг сайжруулна.
- 20.2. Аймаг, сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг авна.

- 20.3. Чойбалсан хотын хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээж, хог дахин ялгах, боловсруулах цогц байгууламжийг байгуулна.
- 20.4. Чойбалсан хот, Баян-Дун сумдад хог хаягдлыг ачиж, тээвэрлэх зориулалтын машин, төвлөрсөн хогийн цэг дээр ажиллах машин механизм, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл бусад тоног төхөөрөмжөөр хангана.
- 20.5. Чойбалсан хот, Баян-Дун сумдын төвлөрсөн хогийн цэгийг ландфилл технологийн дагуу булаах ажлыг загвар болгон хийнэ.
- 20.6. Сумын төвийн хогийн цэгүүдийн талбайг багасгаж, тэг гортиг татан тэмдэгжүүлж, эрүүл ахуйн стандарт шаардлагад нийцүүлнэ.
- 20.7. Сум бүр цахим болон цахилгаан хэрэгслийн хаягдал болон том овортой хог хаягдлыг цуглуулах зориулалтын цэгтэй болно.
- 20.8. Усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсийн хилийг тогтоож тэмдэг, тэмдэгжүүлэлт хийнэ.
- 20.9. Уул уурхай, жижиг, дунд үйлдвэрүүдийн ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, усны төлбөрт тавих хяналтыг сайжруулна.
- 20.10. Уул уурхайн ус ашиглалт, бохирдолтод тавих байнгын хяналтыг сайжруулж, газрын доорх усны нөөцийн хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.
- 20.11. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллого, бүртгэлийн ажлыг жил бүр зохион байгуулж, бохирдуулагч нь төлөгч байх зарчмыг хэрэгжүүлнэ.
- 20.12. Агаарын чанарыг сайжруулах дэд хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулах, агаарын бохирдлын мониторингийн сүлжээг өргөтгөх, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.
- 20.13. Чойбалсан хотын захын гэр хорооллын айлуудыг түлшний хэмнэлттэй утаа бага ялгаруулдаг зуух, дулаан баригч, цахилгааны хэмнэлттэй халаагуур ашиглахад дэмжлэг үзүүлнэ.
- 20.14. Уул уурхай, дэд бүтцийн байгууламжийг байгуулахад эвдрэлд орсон газруудыг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг холбогдох эрх бүхий байгууллагаар хийлгэж, байнгын хяналтыг сайжруулна.
- 20.15. Эзэнгүй эвдэгдэж орхигдсон газруудад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран эзэн холбогдогчийг тогтоон, нөхөн сэргээлт хийнэ.
- 20.16. Хот, суурин, уул уурхайн орчим дахь хөрсний бохирдлын судалгааг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж, бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 20.17. Уул уурхайн олборлолтын бүтээгдэхүүн, бараа, материал тээвэрлэх автозамын хатуу хучилттай болгож, хяналтыг сайжруулна.
- 20.18. Уул уурхайгаас үзүүлсэн нөлөөллийн хохирлыг өөр газарт дүйцүүлэн хамгаалах судалгааны ажлыг хийлгэж, хамгаалах үйл ажиллагааг нь эхлүүлнэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Хатуу хог хаягдал, бохир усыг боловсруулж, дахин ашиглах алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 20.19. Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас авсан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн зарцуулалтыг олон нийтэд ил тод байдлаар тайлагнан, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүгийн зохицуулалтыг сайжруулна.

- 20.20. Иргэд хог хаягдлаа дахивар, аюултай, энгийн гэсэн ангиллаар зориулалтын уут саванд ангилан, хогийн цэгт хаях дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.
- 20.21. Хог тээвэрлэлтийн тогтолцоонд иргэд, аж ахуй нэгжийн ангилсан хог хаягдлыг тус, тусад нь тээвэрлэх, хогийг дахин ангилах менежментийг сайжруулна.
- 20.22. Аймаг, сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийг тогтсон хугацаанд ландфилл технологийн дагуу булаах ажлыг хийж, хог тархахаас сэргийлнэ.
- 20.23. Аюултай хог хаягдлыг цуглуулж хадгалах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй стандартад нийцсэн байгууламж барьж, аюултай хог хаягдлыг дахин ашиглах боломжийг судална.
- 20.24. Дашбалбар, Матад, Баяндун сумдад тохирсон хүчин чадалтай, олон улсын стандартад нийцсэн хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.
- 20.25. Мэнэнгийн сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад хаягдал усны 25 орчим хувийг технологийн хэрэгцээнд дахин ашиглах шаардлага тавин, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.
- 20.26. Аймгийн хэмжээнд газрын хэвлийн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын үр дүнд мониторинг хийнэ.
- 20.27. Уул уурхайн хаягдал усыг цэвэршүүлэхгүй эсвэл дутуу цэвэршүүлэн байгальд хаях явдлыг бүрэн хязгаарлана.
- 20.28. Уул уурхайн дүйцүүлэн хамгааллын ажлын 50 хувийг Дорнод аймгийн төв Чойбалсан хотод, 50 хувийг тухайн сумын газар нутагт хийлгэнэ.
- 20.29. Хүнсний бус үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорхи усны ашиглалтыг хязгаарлана.

Зорилт 21. Хамгаалалтад авах шаардлагатай экосистем, биологийн чухал ач холбогдолтой газруудыг улсын тусгай хамгаалалтад авна.

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нутгийг өргөжүүлэх алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 21.1. Олон улсад тусгай хамгаалалттай газар нутгийг сонгон авах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан, хамгаалалтад авах шаардлагатай газруудыг судалгаагаар нарийвчлан тогтоох ажлыг олон улсын болон байгаль орчны судалгаа, шинжилгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хийнэ.
- 21.2. Дэлхийд болон Монголд нэн ховор, ховор амьтан, ургамлын түлхүүр экосистем бүхий нутгийг тусгай хамгаалалтад авч, 2020 онд аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 20 хувьд хүргэнэ.
- 21.3. Улз голын сав газар дахь гол, рашаан, булгийн эх бүрэлдэх хэсгийг хашиж хамгаална.
- 21.4. Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг мэргэжлийн байгууллагаар судлуулж, сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авна.
- 21.5. Тарваганы тархац нутгийг нэмэгдүүлэхэд нутгийн иргэдийн санал, хяналтад тулгуурлан, дахин нутагшуулах ажлыг зохион байгуулна.
- 21.6. Дорнод аймгийн брэнд цагаан зээрийн гадагш чиглэсэн нүүдлийг сааруулах, хууль бус агналтыг багасгах ажлыг эрчимжүүлнэ.

- 21.7. Загас агнуурын квотын хэмжээг загасны нөөцийн судалгаанд тулгуурлан тодорхойлж, олборлох эрх бүхий байгууллагад тавих хяналтыг өндөржүүлнэ.
- 21.8. Их Хянганы нуруун дахь элбэг тоотой хөхтөн амьтдаас тусгай хамгаалалттай бусад газруудад нутагшуулах асуудлыг судална.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Биологийн олон янз байдлыг хадгалах үүднээс түлхүүр экосистем бүхий газар нутгийг хамгаална.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 21.9. Улз-Онон гол, Хэрлэн гол, Буйр нуур-Мэнэнгийн талын сав газарт хамаарагдах голын урсац бүрэлдэх эх, булаг шандын эхийг хашиж хамгаална.
- 21.10. Зайлшгүй хамгаалах шаардлагатай газар нутгийн судалгаанд үндэслэн, аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд хүргэнэ.
- 21.11. Нэн ховор, ховор эмийн болон аж ахуйн өндөр ач холбогдолтой ургамлыг зориудаар, орчин үеийн биотехнологийн аргаар тарималжуулан, ургамлын селекцийн лабораторийг Дорнод аймгийн их, дээд сургуулиудтай хамтран байгуулна.
- 21.12. Нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан байгаль хамгаалах ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг тогтмол нэмэгдүүлнэ.
- 21.13. Биологийн төрөл зүйлийн тоо толгой, тархацыг олон улсын болон байгаль орчны судалгаа, шинжилгээний мэргэжлийн байгууллагатай хамтран нарийвчилсан судалгааг хийнэ.
- 21.14. Олон улсын байгууллагуудын тусламж, дэмжлэгээр зэрлэг ан, амьтдын судалгаа, хамгаалалтад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

*Зорилт 22. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөгжлийг хангана.*

*Нэгдүгээр үе шат (2016-2020): Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эмзэг байдал, гамшгийн эрсдлийг бууруулна.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 22.1. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөө, Ногоон хөгжлийн үзэл баримтлал, ойлголтыг иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд түгээн, сургалт сурталчилгааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 22.2. Баян-Уул, Баяндун сумын ойн мэргэжлийн анги байгуулан, ойн цэвэрлэгээ хийх ажлыг тогтмол зохион байгуулна.
- 22.3. Ойн зурвас байгуулах замаар газар тариалан, хот, суурин, автозам, уул уурхайн орчимд үүссэн газрын доройтол, цөлжилтийг бууруулна.
- 22.4. Ойн цэвэрлэгээнээс гарсан модыг түлшинд ашиглан, хэрэглээний зориулалтаар ургаа мод унагахыг багасгана.
- 22.5. Ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэн, ойжуулсан талбайг арчилж, тордох, хамгаалах ажлыг сайжруулна
- 22.6. Ойн нөхөрлөлүүдийн ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааг үнэлэн, үйл ажиллагааг нь чанаржуулах ажлыг зохион байгуулна.

- 22.7. Хулгайн мод бэлтгэлийг зогсооход мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулж, хулгайн мод бэлтгэгчдэд ногдуулах торгуулийн арга хэмжээг нэмэгдүүлнэ.
- 22.8. Ойн нөөц бүхий талбайн хэмжээг 3-5 хувиар нэмэгдүүлнэ.
- 22.9. Аймаг болон сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд отор, нөөц бэлчээр, хадлангийн газар болон бэлчээр нутгаа улирлаар сэлгэн хуваарьтай ашиглах менежментийг сайжруулна.
- 22.10. Гадаргын усны хомсдолтой бэлчээрт гүний худаг гарган, худаг, гадаргын ус дагасан бэлчээрийн талхагдлыг багасгана.
- 22.11. Ой, хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зориулалтаар байнгын шороон болон халз зурвас байгуулан, намар, хаврын улирлуудад сэргээн сайжруулдаг болно.
- 22.12. Ойн болон бэлчээрийн хөнөөлт шавьж, мэрэгчидтэй тэмцэх ажилд байгаль орчинд халгүй биологийн арга нэвтрүүлнэ.
- 22.13. Цаг уурын өртөөний сүлжээг өргөтгөн, цаг уурын хяналт шинжилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
- 22.14. Болзошгүй байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед хэрэглэх хүнс, шатахуун, хөрөнгийн нөөцийг орон нутгийн төсвөөс бүрдүүлнэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025): Гамшигийн эрсдлээс урьдчилан сэргийлэх технологийг нэвтрүүлэн, экосистемийн үйлчилгээг сайжруулан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 22.15. Мод үржүүлгийн аж ахуй эрхэлдэг байгууллагуудад далд үндэсний тарьц бойжуулах технологийг нэвтрүүлж, хүчин чадал, техник технологи, санхүүгийн чадамжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 22.16. Цөлжилтөд нэн хүчтэй өртөж байгаа Матад, Чулуунхороот, Гурванзагал, Халхгол сумдад, ганд тэсвэртэй тухайн орчинд тохирсон мод, сөөг түлхүү тарина.
- 22.17. Хил дамнасан түймрээс хамгаалах зорилгоор татсан зурвас бүсийг сайжруулах, түймэр унтраахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс урамшуулал олгон, шаардлагатай багаж хэрэгслээр хангана.
- 22.18. Цөлжилт, ган, ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах чиглэлээр цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулан, дэмжлэг үзүүлнэ.
- 22.19. Цаг агаар, байгалийн аюулт үзэгдэл, бэлчээр ашиглалт, ургамлын гарцын урьдчилсан мэдээ, мэдээллийг малчид, иргэдэд шуурхай хүргэх технологийг нэвтрүүлнэ.
- 22.20. Бэлчээрийн ургацын мэдээнд тулгуурласан бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээллэх тогтолцоог нэвтрүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулахад ашиглана.
- 22.21. Хот, суурин газрын ундны усны нөөцийн хайгуул, судалгааг геофизик-гидрогеологийн мэргэжлийн байгууллагуудаар хийлгэнэ.
- 22.22. Хэрлэн голд урсацын тохируулга хийж, усны нөөц хуримтлуулан ашиглах олон зориулалттай цогцолбор байгуулах боломжийг судална.
- 22.23. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицох чадвартай ургамал, амьтны төрөл зүйлийн судалгаа хийж, хяналтыг сайжруулна.
- 22.24. Цас, борооны ус хуримтлуулж, усан сан, хөв цөөрөм байгуулж болох боломжит газрын судалгааг хийж, тэдгээрийг байгуулна.



## **БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 11. ИРГЭДИЙН СУУРЬ ХЭРЭГЦЭЭГ БҮРЭН ХАНГАСАН, АМГАЛАН ТАЙВАН АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН ХОТ СУУРИНГ ХӨГЖҮҮЛНЭ.**

Зорилт 23. Хот суурин газрын ус, дулаан хангамж, ариутгах татуургын найдвартай байдлыг хангаж, хүн амын тохитой, цэвэр орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Амьдрах таатай орчин бүрдэхэд тулгарч буй суурь, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх алхам.*

### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 23.1. Чойбалсан хотын механик цэвэрлэх байгууламжийг иж бүрэн шинэчлэн сайжруулна.
- 23.2. Чойбалсан хотын ус хангамжийг найдвартай ажиллагааг хангах зорилгоор гүний хоёр худгийг шинээр байгуулна.
- 23.3. Чойбалсан хотын бохир усны даралттай шугамуудыг шинэчлэн сайжруулна.
- 23.4. Чойбалсан хотын ундны усны эх үүсвэрийн цуглуулах шугамыг шинэчилж хотын ундны усны найдвартай байдлыг хангана.
- 23.5. Чойбалсан хотын дулааны цахилгаан станцад өргөтгөл, шинэчлэлийн ажлыг хийж, шинээр баригдах 1000 айлын орон сууц, гэр хорооллын дахин төлөвлөлтийн орчин, нийтийн орон сууц, үйлдвэр, аж ахуйн нэгжийн хэрэгцээг хангана.
- 23.6. Чойбалсан хотын талбайн гадаргуугийн ус зайлуулах болон цуглуулах байгууламжийн зураг, төслийн ажлыг хийлгэнэ.
- 23.7. Хэрлэн сумын I, VIII багт бага оврын цэвэрлэх байгууламжийг байгуулж орчны бохирдлоос сэргийлнэ.
- 23.8. Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг байгуулна.
- 23.9. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу усан хангамж, ариутгах татуурга, дулааны нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үзүүлэлтийг үе шаттайгаар хийлгэнэ.
- 23.10. Сумдыг евро стандартад нийцсэн ундны ус цэвэршүүлэх, шүүгч төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллагааг бүрэн хангана.
- 23.11. Сумын төвүүдэд халуун усны газрын хүрэлцээг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 23.12. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримтлан газар олголтын асуудлыг шийдвэрлэнэ.
- 23.13. Хүн ам ихээр төвлөрсөн Баян-Уул, Цагаан-Овоо, Халхгол, Дашбалбар сумдад сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хувийн тохилог орон сууц барих хотхон хорооллын газрыг олгож, инженерийн шугам сүлжээг байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он): Сумдын ус, дулаан хангамж, ариутгах татуургын асуудлыг бүрэн шийдэх алхам.*

### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 23.14. Чойбалсан хотын цэвэр, бохир усны магистрал болон салбар шугамуудыг хот төлөвлөлттэй уялдуулан үе шаттайгаар сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ.

- 23.15. Хилийн боомтууд, уул уурхайн суурин, аялал жуулчлалын баазуудад орчин үеийн стандартад нийцсэн нийтийн бие засах газар, халуун усны газар зэрэг ариун цэврийн суурь үйлчилгээг хангах шаардлага тавьж, хэрэгжилтийг үе шаттайгаар хангуулна.
- 23.16. Хөдөөгийн сумдад усан хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулна.
- 23.17. Чойбалсан хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, ус хангамж, ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.
- 23.18. Усны зохистой хэрэглээг хэвшүүлж, усны алдагдал хамгийн бага аймаг болно.
- 23.19. Чойбалсан хотод дахивар, аюултай, энгийн гэсэн ангилалтай хогийн савыг гудамж, олон нийтийн газар, байгууллага аж ахуй нэгж, орон сууц, гэр хорооллын хэрэгцээнд нийцүүлэн овор хэмжээ, дизайны ялгаатай байдлаар хүрэлцээтэй хэмжээгээр байршуулна.
- 23.20. Чойбалсан хотын ус цэвэршүүлэх байгууламжаас стандарт түвшинд хүртэл цэвэрлэгдсэн саарал усыг хотын сүлжээнд дамжуулах шугам сүлжээний зураг төслийг хийлгэнэ.

**Зорилт 24:** Үлгэр жишээ ухаалаг, ногоон хот, сууринг байгуулж, хүн амын тохитой амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

*Нэгдүгээр үе шат (2016-2020 он): Хоггүй цэвэр, эмх цэгцтэй, цэвэр агаартай, ногоон байгууламжтай хот, сууринг байгуулахад чиглэсэн алхам.*

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 24.1. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сум бүрээр боловсруулж, батлуулна.
- 24.2. Сумдын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ.
- 24.3. Чойбалсан хотын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах үүднээс малтай иргэдийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан байршилд дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн нүүлгэн шилжүүлнэ.
- 24.4. Чойбалсан хотын хогийн цэгийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нүүлгэн шилжүүлнэ.
- 24.5. Ногоон орчинг бүрдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг байнгын, өрсөлдөөнт, сайн дурын хэлбэрээр өрнүүлнэ.
- 24.6. Аймаг, сумын төвийн хог хаягдал булаах төвлөрсөн цэгийг хоторчны бохирдол үүсэхгүй байхаар тохижуулж, мод тарьж, хашаажуулна.
- 24.7. Аймаг, сумын төвийн явган хүний замыг сайжруулж, стандартад нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, байдлаар нэмэгдүүлнэ.
- 24.8. Чойбалсан хотын нийтийн орон сууцны байшингуудын дээврийг засварлах, гадна фасадыг шинэчлэх, гадна орчныг тохижуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 24.9. Чойбалсан хотын ирээдүйн тэлэлт, хүн амын өсөлтийг хангах, улсын зэрэглэлтэй хот болгох үүднээс хил залгаа орших сумдыг нэгтгэх боломжийг судлаж, шийдвэрлэнэ.
- 24.10. Шахмал түлш үйлдвэрлэх хувийн хэвшлийн санаачилгыг хөнгөлөлттэй зээл, татварын урамшууллын механизмаар дэмжинэ.
- 24.11. Чойбалсан хотын найрамдал цэцэрлэгт хүрээлэнг гүйлтийн болон дугуйн зам бүхий цэцэрлэгт хүрээлэн болгож өргөжүүлнэ.
- 24.12. Аймаг, сумын төвийн хаягжуулалт, тэмдэглэгээг нэгдсэн стандартаар хийнэ.
- 24.13. Аймаг, сумын төвийн гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.

- 24.14. Аймаг, сумын төвийн гэр хорооллыг дахин төлөвлөх, барилгажуулах төлөвлөгөөг боловсруулна.
- 24.15. Хүн амын орон сууцны хангамжийг сайжруулах үүднээс Чойбалсан хотод 1000 айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 24.16. Алслагдсан Халхгол болон Чулуунхороот зэрэг сумдад хүн амын тогтвортой суурьшлыг нэмэгдүүлэх үүднээс бусад аймаг, сумдаас хүн ам шилжин ирж суурьшихыг дэмжинэ.
- 24.17. Иргэдийн аюулгүй, тайван амьдрах орчныг бүрдүүлэх үүднээс хот, суурин газрын гудамж, зам, нээлттэй талбай, олон нийтийн зорчих хэсгүүдийг үе шаттайгаар бүрэн камержуулах, гэрэлтүүлэгтэй болгох, мөн олон нийтийн эргүүлийн цагдаа ажиллуулах зэрэг ажлыг хэрэгжүүлнэ.

*Хоёрдугаар үе шат (2021-2025 он): Ухаалаг, ногоон хотыг бий болгох бүтээн байгуулалтын алхам.*

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- 24.18. Чойбалсан хотод байнгын ажиллагаатай хог ялгах, боловсруулах үйлдвэрийг байгуулна.
- 24.19. Аймаг, сумын төвийн явган хүний замыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 24.20. Чойбалсан хотын нийтийн орон сууцны байшингуудын дээврийг засварлах, гадна фасадыг шинэчлэх, гадна орчныг тохижуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 24.21. Сум, аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй эко-нийтийн бие засах газруудыг барьж ашиглана.
- 24.22. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээгээр улсдаа тэргүүлэх хот, суурин газруудтай болно.
- 24.23. Нийтийн тээвэр, ахуйн хэрэглээнд хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор хийн түлш үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.
- 24.24. Иргэдийн интернет ашиглан мэдээлэл авах, бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэх бололцоог нэмэгдүүлэх зорилгоор үнэгүй интернетийн сүлжээнд холбогдох бүсүүдийг аймгийн төвд бий болгоно.
- 24.25. Аймаг болон сумдын төвийн ерөнхий өнгө төрх, гудамж талбайг орчин үеийн хот суурингийн жишгээр шинэчилнэ.
- 24.26. Архитектурын өвөрмөц шийдэл бүхий хуучны дурсгалт барилга байгууламж, хөшөө дурсгалыг сэргээн засварлана.
- 24.27. Гэр хорооллыг барилгажуулах, дахин төлөвлөх ажлыг эхлүүлж 30 хувьд хүртэл барилгажуулна.
- 24.28. Матад сумын төвийг газрын тосны 19-р талбайгаас Баянхошуу боомт хүрсэн хатуу хучилттай автозамын дагууд шилжүүлэн байршуулах асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

# ДОЛОО. ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## Зохицуулах харилцаа, эрхзүйн үндэслэл

“Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, 2030 он хүртэлх төсөөлөл”-ийг Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 11 сарын 26 ны өдөр баталсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуульд нийцүүлэн боловсруулав. Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үйл явцад үнэлгээ өгөхөд хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтална.<sup>7</sup>
2. Аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс тус хуулийн 15, 16 дугаар зүйлийн дагуу сум, багийн түвшинд үүнтэй уялдаа холбоо бүхий дунд хугацааны баримт бичгийг боловсруулан ажиллана.
3. Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтын баримт бичгийн төслийг хэвлэн нийтлэх, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 19-р зүйлийн дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.
4. Аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх байнгын бүтэц, тогтолцоог бий болгоно.
5. “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, 2030 он хүртэлх төсөөлөл”-ийг батлахтай холбогдон “Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2016”-ыг батлах тухай 2009 оны 12 сарын 25-ний өдрийн Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 -р хуралдааны 2-ртогтоолын хэрэгжилтийг дуусгавар болгоно.

## Удирдлага, зохион байгуулалт

Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь аймаг, сум, багийн Засаг дарга нарын түвшинд дараах уялдаа холбооны хүрээнд хэрэгжинэ.

- Хөгжлийн хэтийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутаг, засаг захиргааны нэгж, газар хэлтэс, тэдгээрийн удирдлага өөрсдийн чиг үүрэгт хамаарах салбар нэгжийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангана.
- Аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь энэхүү хэтийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- Хөгжлийн хэтийн зорилтын тайланг жил бүр гаргаж, дараа оны эхний улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.
- Аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, хөндлөнгийн дүгнэлт гаргуулахад “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 14.6-г баримтална.

---

<sup>7</sup>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай Монгол улсын хууль, 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр, УИХ

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн, Засаг даргын саналыг үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахад “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийг баримтална.
- Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргаж, үүнийг цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.
- Аймаг, сум, багийн хэмжээнд иргэд, олон нийтийн байгууллагын хяналтыг бий болгож, оролцоог ханган ажиллана.
- Төрийн байгууллагууд аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн чиг үүрэгт хамаарах ажил, арга хэмжээний хүрсэн үр дүн, ололт амжилт, гарсан алдаа дутагдал, түүнээс авах сургамж зэрэг цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай гаргаж, түгээх, сурталчлах үйл ажиллагааг явуулна.

### **Санхүүгийн эх үүсвэр**

Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэхэд санхүү, төсвийн дараах эх үүсвэрүүдийг ашиглана. Үүнд:

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Монгол Улсын Хөгжлийн банк
- Орон нутгийг хөгжүүлэх сан
- Засгийн Газрын тусгай сангууд
- Гадаадын хөрөнгө оруулалт
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- Төр хувийн хэвшлийн түншлэл, концесс
- Бусад эх үүсвэр (Хавсралт 3-т олон улсын хөнгөлттэй зээл, тусламж, техникийн зөвлөгөө өгдөг байгууллагуудын жагсаалтыг оруулав).

Хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр шаардагдах хөрөнгө оруулалтыг тусгасан хүснэгтийг Хавсралт 1-т оруулав.

### **Хяналт, шинжилгээ үнэлгээ:**

Аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, үр дүнг дүгнэх үе шатууд нь “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн дагуу явагдах бөгөөд хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

- Эхний шатны үнэлгээ (Хугацаа: 2018 оны IV улирал)
- Хоёр дахь шатны үнэлгээ (Хугацаа: 2020 оны IV улирал)
- Гурав дахь шатны үнэлгээ (Хугацаа: 2022 оны IV улирал)
- Дөрөв дэх шатны үнэлгээ (Хугацаа: 2024 оны IV улирал)
- Тав дахь шатны үнэлгээ (Хугацаа: 2026 оны I улирал)

Хөгжлийн хэтийн зорилтын хяналт шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай зардлыг аймгийн төсөвт тусган санхүүжүүлэх бөгөөд холбогдох төрийнболон мэргэжлийн, төрийн бус байгууллагууд, орон нутгийн иргэдийн оролцоог зайлшгүй хангана.

Хэтийн зорилтын хэрэгжилтэд олон нийтийн хяналт, оролцоог хангах дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

